

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ 2023 ᠣᠨᠢ  
ᠨᠡᠭᠦᠳᠦᠰᠦᠨ ᠲᠥᠰᠦᠪᠢᠶᠢᠨ  
ᠲᠥᠰᠥᠯᠦᠳ ᠥᠭᠦᠰᠣᠨ ᠠᠭᠦᠳᠢᠲᠤᠨ  
ᠳᠦᠭᠦᠨᠡᠯᠲ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



**МОНГОЛ УЛСЫН 2023 ОНЫ  
НЭГДСЭН ТӨСВИЙН  
ТӨСӨЛД ӨГСӨН АУДИТЫН  
ДҮГНЭЛТ**

2022 он



МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН  
ТУШААЛ

2022 оны 10 сарын 06 өдөр

Дугаар А/74

Улаанбаатар хот

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.9, 29.1.10 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.2, 20.3, 20.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. “Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн 2023 оны Монгол Улсын нэгдсэн төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргах” аудитын тайланг хавсралт ёсоор баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Монгол Улсын Их Хурал, Засгийн газар, Сангийн яаманд хүргүүлэхийг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч (Я.Сарансүх)-д даалгасугай.

3. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга (Д.Амарбаясгалан), Сангийн сайд (Б.Жавхлан) нарт тус тус зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газар (Ц.Энхжавхлан)-т даалгасугай.

5. Аудитын ажлын болон нотлох баримтыг 2022 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор архивын нэгж болгон Үндэсний аудитын газрын архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг (Аудитын удирдлагын менежер Ж.Батсайхан)-т үүрэг болгосугай.



Д.ЗАНДАНБАТ



АГУУЛГА

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдээгдэл .....	2
<b>НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ</b> .....	4
Монгол Улсын 2023 оны макро эдийн засаг ба төсвийн бодлого, төлөвлөлтийн талаарх ерөнхий нөхцөл байдал .....	4
<b>ХОЁР. ТӨСВИЙН ТӨСӨЛ ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОДЛОГОД НИЙЦСЭН ЭСЭХИЙГ ҮНЭЛЖ ДҮГНЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ ТОДОРХОЙГҮЙ БАЙНА</b> .....	4
Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг хөгжлийн бодлогын баримт бичиг, түүний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэх шаардлагатай байна.....	5
<b>ГУРАВ. ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙГ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЭХГҮЙ БАЙНА</b> .....	10
Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан тусгай шаардлагыг хангаж байна .....	10
Төсвийн хүрээний мэдээгдлийг төсвийн төсөлд нийцүүлэн өөрчилдөг дутагдал давтагдаж байна.....	11
<b>ДӨРӨВ. ТӨСВИЙН ОРЛОГЫГ НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖ БАЙНА</b> .....	12
Төсвийн урсгал зардлыг бууруулах боломжтой байна .....	14
<b>ТАВ. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА</b> .....	22
<b>ДҮГНЭЛТ:</b> .....	23
<b>ЗӨВЛӨМЖ:</b> .....	25
<b>ХАВСРАЛТУУД:</b> .....	26



**Аудит хийх  
үндэслэл, бүрэн  
эрх**

**Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, 31 дүгээр зүйлийн 31.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7 болон Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсэг, УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2021 оны “Аудитын сэдэв батлах тухай” 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Монгол Улсын Ерөнхий аудиторын “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” 2022 оны А/12 дугаар тушаалын дагуу Төрийн аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэлээ.

**Аудитын зорилго**

Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2023 оны төсвийн төслийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэйгөөр боловсруулж, төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулан эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад чиглүүлсэн эсэхэд аудитын зорилго чиглэсэн. Энэ зорилготой холбоотой дараах асуудлын хүрээнд аудитыг төлөвлөж гүйцэтгэв. Үүнд:

- Төсвийн төсөл нь улсын тогтвортой хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцсэн эсэх;
- Төсвийн төсөл нь Төсвийн тухай хууль тогтоомжид заасан шалгуурыг хангасан эсэх;
- Төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар санал тусгасан эсэх;

**Аудитын арга зүй,  
шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчимд тулгуурласан Төрийн аудит MNS 6817:2020 Монгол Улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, аудитыг чиглүүлж гаргасан бусад заавар, аргачлал, гарын авлагыг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, арга зүйн дагуу аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, аудитын дүн, дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг зохих журмын дагуу цуглуулж ажлын баримт материалд хавсаргасан болно.

Аудитад төсөв боловсруулах, өргөн мэдүүлэх, батлах ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, журам, заавар аргачлал, түүний дотор Төсвийн тухай хуулийн 5 дугаар бүлэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсэгт заасан шаардлагыг гол шалгуур болголоо.

**Аудитын хамарсан  
хүрээ**

Аудитыг Монгол Улсын нэгдсэн төсөв /улсын төсөв, орон нутгийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сан, Нийгмийн даатгалын сан, бусад тусгай сангууд/-ийн 2021, 2022 оны батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэл /батлагдсан болон урьдчилсан/, 2023 оны төсвийн төсөл, төсвийн ерөнхийлөн захирагчид болон төсөл, хөтөлбөрүүдийн үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтүүд, төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн үйл ажиллагааг хамруулан гүйцэтгэв.



**Талуудын хүлээх  
үүрэг, хариуцлага**

Аудитад Монгол Улсын 2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хүрээнд цуглуулсан төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсөвт байгууллагуудын үйл ажиллагааны үр дүн, санхүүгийн үзүүлэлт зэргийг ашиглав.

Сангийн яам ТЕЗ-дын төсвийн саналыг холбогдох шаардлагад нийцүүлэн нэгтгэн боловсруулж, Засгийн газарт өргөн мэдүүлэх үүрэгтэй.

Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2023 оны төсвийн төслийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулсан эсэхэд аудит хийж, Төсвийн тухай хуульд заасан хугацаанд дүгнэлт гаргах нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

**Аудитын  
бүрэлдэхүүн,  
хугацаа**

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Сарансүх, Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Энхжавхлан, Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд нар хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын удирдлагын менежер Ж.Батсайхан хэрэгжүүлж, аудитын менежер Д.Энхдалай, Ц.Хосжаргал, Б.Саруул, Б.Анхбаяр, ахлах аудитор Б.Хишигтогтох, Л.Мөнхцацрал, А.Даваадорж, Б.Батдэлгэр, аудитор Б.Мөнхцэцэг, П.Амарсанаа, С.Бат-Эрдэнэ, О.Баярмаа, Ж.Мөнхбилгүүн, гэрээт ажилтан И.Дөлгөөнтуул нар гүйцэтгэв.

**Хүндрэл бэрхшээл**

Аудитыг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр эхлүүлж, хуанлийн 5 хоногт гүйцэтгэсэн нь аудитын цар хүрээг хязгаарлах нөхцөл боллоо.



## НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

### **Монгол Улсын 2023 оны макро эдийн засаг ба төсвийн бодлого, төлөвлөлтийн талаарх ерөнхий нөхцөл байдал**

1.1 Дэлхий дахинд 2023 онд геополитикийн зөрчилдөөн үргэлжлэх, хөгжингүй орнуудын Төв банкнуудын хэрэгжүүлж буй мөнгөний хатуу бодлого эрчимжих, БНХАУ-ын эдийн засгийн өсөлт саарах, КОВИД-19 цар тахлын болзошгүй шинэ давлагаа үүсэх зэрэг эрсдэлтэй нөхцөл байдал үргэлжлэхээр байна.

1.2 Монгол Улсын ДНБ-ий бодит өсөлт 2021 онд 1.4 хувь, төсвийн алдагдал ДНБ-ий 7.1 хувийг эзэлж байсан бол 2022 оны эхний 8 сарын байдлаар ДНБ-ий бодит өсөлт 2.6 хувь, инфляц 14.8 хувьтай байгаа бөгөөд тээвэр ложистикийн хүндрэлгүй, нүүрсний экспорт эрчимжих тохиолдолд эдийн засаг энэ онд 3 орчим хувь өсөх, инфляц алгуур буурах хүлээлттэй байна.

1.3 Монгол Улсын 2023 оны төсвийн төсөлд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ 18.9 их наяд төгрөг буюу ДНБ-ий 34.7 хувь, нийт зарлагын хэмжээ 20.5 их наяд төгрөг буюу 37.6 хувь, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1.5 их наяд төгрөгийн алдагдалтай буюу ДНБ-ий 2.8 хувь байхаар төлөвлөжээ.

1.4 Төсвийн төслийн танилцуулгад хямралын үеийн эдийн засгийг тогтворжуулах, төлбөрийн тэнцлийн алдагдлыг бууруулах, төсвийн зарлагын өсөлтийг хязгаарлах, төсвийн хумих бодлогыг мөнгөний бодлоготой уялдуулан хэрэгжүүлэхээр дараах зорилтуудыг тусгасан байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх;
- Шинэ сэргэлтийн бодлогыг дэмжих;
- Нөөцийг оновчтой хуваарилах;
- Эдийн засгийг тогтворжуулах.

1.5 УИХ-д өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн төсөл, танилцуулга, аудитын явцад цуглуулсан баримт нотолгоонд үндэслэн хөгжлийн бодлого болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцсэн эсэх, төсвийн орлого, зарлагын төлөвлөлт, түүний үндэслэл, төсвийн үр ашгийг дээшлүүлэх талаарх аудитын дүн, дүгнэлт, зөвлөмжийг дараах бүлгүүдэд тусгав.

### **ХОЁР. ТӨСВИЙН ТӨСӨЛ ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОДЛОГОД НИЙЦСЭН ЭСЭХИЙГ ҮНЭЛЖ ДҮГНЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ ТОДОРХОЙГҮЙ БАЙНА**

1.6 Төрийн аудитын байгууллага УИХ-аас 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.1-д “Төсвийн төсөл нь ... үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцсэн эсэх” гэж заасан шаардлагыг хангасан байх, мөн хуулийн 22.3 дахь хэсэгт заасны дагуу уг асуудлаарх аудитын дүгнэлт гаргах хуулийн зохицуулалттай болсон.

1.7 УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд заасан Эдийн засгийн аюулгүй байдалд хамаарах дараах бодлогын хэрэгжилт хангалтгүй байгаа бөгөөд төсвийн төсөлд тусгасан төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2023 онд хэрэгжүүлэхээр тусгасан хөтөлбөр, хөтөлбөрийн үр дүнгийн үзүүлэлт Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4<sup>1</sup> дэх

<sup>1</sup> Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4. Үндэсний аюулгүй байдал нь дараахь бүрэлдэхүүн хэсэгтэй байна:



хэсэгт заасан аюулгүй байдлыг хангахад чиглэсэн эсэх нь тодорхойгүйгээс иж бүрэн дүгнэлт өгөх боломж хязгаарлагдмал байна. Тухайлбал:

- Хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлого – “Гадаадын аль нэг орноос хийгдэх хөрөнгө оруулалтын хувь, хэмжээг гадаадын нийт хөрөнгө оруулалтын гуравны нэгээс хэтрэхгүй байлгах бодлого баримтална...” гэж заасан хэдий ч сүүлийн 5 жилийн байдлаар гадаадын шууд хөрөнгө оруулалтын 36.7-60.4 хувь нь Канад улсад ногдсон;
- Төсөв, санхүүгийн салбарын аюулгүй байдал – “Гадаад валют, алтны нөөцийг үндэсний импортын нэг жилийн хэрэгцээг хангах хэмжээнээс багагүй түвшинд байлгана ...” гэж заасан хэдий ч хэрэгжилт хангалтгүй, гадаад валютын албан нөөц 2.3 тэрбум ам.доллар орчимд хүрч буурсан;
- “... Байгаль орчинд сөрөг нөлөө багатай, хямд эрчим хүчний үйлдвэрлэлийг хөгжүүлж, 2020 он гэхэд нүүрс болон дотоодын бусад эх үүсвэрээр түлш, эрчим хүчний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангана” гэж заасан хэдий ч 2018-2020 онд 1,683.6-1715.8 сая кВт эрчим хүчийг импортлосон;
- “Газрын тосны бүтээгдэхүүнээр нэг орноос шууд хараат байдлыг багасгаж, улмаар 2020 он гэхэд дотоодын үйлдвэрлэлээр хэрэгцээгээ бүрэн хангана...” гэж заасан хэдий ч дотоодод үйлдвэрлэж эхлээгүй;

1.8 Мөн Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1-д хуулийн төслийн агуулга “... үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх” гэж заасан хэдий ч уялдсан эсэхийг үнэлэх шалгуургүй байна.

**Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг хөгжлийн бодлогын баримт бичиг, түүний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэх шаардлагатай байна**

2.1 Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, яам нь Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1<sup>2</sup>-д заасан 4 жилийн стратеги төлөвлөгөөг Монгол Улсын хөгжлийн урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилго, зорилтуудтай уялдуулан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлагдсанаас хойш хоёр сарын дотор боловсруулж, батлахаар заасан байна.

2.2 Төрийн захиргааны төв байгууллага стратеги төлөвлөгөөнд тусгасан зорилтын хүрээнд хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээг Төрийн албаны тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1<sup>3</sup>-д заасан байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган жил бүрийн 01 дүгээр сарын 05-ны өдрийн дотор батлах, хэрэгжүүлэх зохицуулалттай байна.

2.3 Гэвч төсвийн ерөнхийлөн захирагч нар төсвийн төслийг боловсруулахдаа 2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнгийн чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг стратеги төлөвлөгөө, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн

3.4.1. Монгол Улсын оршин тогтнохын аюулгүй байдал;

3.4.2. нийгэм-төрийн байгууллын аюулгүй байдал;

3.4.3. иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдал;

3.4.4. эдийн засгийн аюулгүй байдал;

3.4.5. шинжлэх ухаан, технологийн аюулгүй байдал;

3.4.6. мэдээллийн аюулгүй байдал;

3.4.7. монгол соёл иргэншлийн аюулгүй байдал;

3.4.8. хүн ам, удмын сангийн аюулгүй байдал;

3.4.9. экологийн аюулгүй байдал.

3.4.10. хүнсний аюулгүй байдал.

<sup>2</sup> Төрийн албаны тухай хуулийн 53.1. Төсвийн ерөнхийлөн захирагч хууль тогтоомжид нийцүүлэн харьяа байгууллагын дөрвөн жилийн стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулна.

<sup>3</sup> Төрийн албаны тухай хуулийн 54.1. Төсвийн шууд захирагч тухайн жилийн Төсвийн тухай хуульд заасан өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний биелэлтийг зохион байгуулах зорилгоор гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан баталж, жил бүрийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийн хооронд хэрэгжүүлнэ.



байдлаар хэрхэн уялдуулж, тооцож, төлөвлөх талаар нарийвчилсан арга зүйгүй, хэрэгжилт хангалтгүй байна.

2.4 Сангийн яамнаас Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2023 оны төсвийн төсөл бэлтгэх удирдамжид "Төсвийн хөтөлбөр, зориулалт арга хэмжээний тайлбар бэлтгэх хүснэгт"-ийг хүргүүлсэн хэдий ч уг судалгааны нэгтгэлийг төсвийн төсөл, танилцуулга, холбогдох хавсралтад тусгаагүй, иж бүрэн бус байгаа нь нөхцөл байдлыг нэгтгэн дүгнэлт өгөх боломжийг хязгаарлаж байна.

2.5 Төсвийн ерөнхийлөн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүн болон дунд хугацааны хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг, хүрэх түвшин, үр дүн хоорондын уялдаа хангалтгүй байгаа бөгөөд төсвийн төслийн Хавсралт 1-д 38 төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэхээр тусгасан 301 хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө, Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан байдлыг үнэлэхэд дараах байдалтай байна. *Дэлгэрэнгүйг Хавсралт 1-с үзнэ үү.*

*Хүснэгт 1 Хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнгийн нийцэл*

Үзүүлэлт	Тусгаагда- агүй	Агуулгын хувьд нийцсэн хэдий ч хүрэх үр дүн зөрүүтэй тусгагдсан	Тусгаагд- сан
Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний шалгуур үзүүлэлт	277	19	5
Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт	265	20	16
Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн шалгуур үзүүлэлт	276	7	18

*Эх сурвалж: Монгол Улсын 2023 оны төсвийн төсөл*

2.6 Эдийн засаг, хөгжлийн яам нь төсвийн төсөл Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцсэн гэж үзэн Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.3<sup>4</sup>-т заасан зөвшөөрлийг 2022 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн 01/1088 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн байна.

2.7 Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан "Шинэ сэргэлтийн бодлого"-д 6 багц асуудлын хүрээнд 29 зорилт, 97 үйл ажиллагаа, хүрэх үр дүнг тодорхойлж, хөгжлийн 20 төслийг хэрэгжүүлэхээр баталсан бөгөөд төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, улсын төсвөөс санхүүжүүлэх төсөл хөтөлбөрийн жагсаалтад дараах төсөл, арга хэмжээг тусгажээ. *Дэлгэрэнгүйг Хавсралт 2-с үзнэ үү/ Тухайлбал:*

- *Боомт хүртэлх зам харилцааг сайжруулж, тээврийн хүчин чадлыг нэмэгдүүлэх:*
  - "Зүүнбаян-Ханги чиглэлийн 226 км төмөр замын ажил",
  - "Бүсийн тээвэр логистикийн шинээр нэмэгдэх төв" хөтөлбөрүүд,
  - "Дорнод аймгийн Хэрлэн сумаас Хавиргын боомт чиглэлийн хатуу хучилттай авто зам, 124.5 км /Дорнод/",
  - "Баян-Уул сумаас Ульхан боомт хүртэлх хатуу хучилттай авто зам, 50 км /Дорнод, Баян-Уул сум/";
- *Төв аймгийн Хөшигийн хөндийд шинэ дагуул болон эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулж хөгжүүлэхэд шаардлагатай дулаан, цахилгааны хангамжийн эх үүсвэр:*
  - "Шинэ нисэх-Зуунмод сумыг холбох 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, 110/35/10 дэд станц /Төв, Зуунмод сум/"
- *Инновац, Аж үйлдвэрийн IV хувьсгал, хиймэл оюун, блокчейн зэрэг технологийн*

<sup>4</sup> Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9.4.3 макро эдийн засгийн бодлого болон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудлыг салбар хооронд шууд удирдан зохион байгуулах бөгөөд улсын төсвийн төсөл Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцэж байгаа эсэх асуудлаар зөвшөөрөл өгөх;





хөгжилд түшиглэсэн шинжлэх ухааны салбарыг хөгжүүлэх хүний нөөцийг бүрдүүлэх:

- “Инновацын тэргүүлэх чиглэлийн үйл ажиллагаанд оролцсон ажиллагчид, иргэдийн тоо (6 тэргүүлэх чиглэл, 11 технологийн хүрээнд)”
- Нийтийн тээврийн чанар, стандартыг сайжруулж, хүртээмжийг нэмэгдүүлэх багтаамж ихтэй нийтийн тээврийн шинэ технологи нэвтрүүлэх:
  - “Шинээр худалдан авах нийтийн тээврийн автобус”, “Цахилгаан автобус цэнэглэх төхөөрөмж бүхий автобусны автопарк”
- Усны нөөцийг хамгаалах, зүй зохистой ашиглах бодлого хэрэгжүүлж, хүн амыг эрүүл ахуйн шаардлага хангасан ундны усаар хангаж, үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн ус хангамжийг сайжруулж, нөөцийн хуримтлал бий болгох:
  - “Ус хангамжийн эх үүсвэрийн нөөц тогтоох хайгуул судалгаа хийх сумын тоо 4;
- Цахим үндэстэн” болох арга хэмжээг эрчимжүүлж, ... цахимаар үзүүлэх төрийн үйлчилгээний хүртээмж, тоог нэмэгдүүлж, иргэнийг цахим гарын үсгээр хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх:
  - Цахим гарын үсэг олгосон Монгол Улсын иргэний тоо /мянга өссөн дүнгээр/ 500” гэж тус тус тусгажээ.

2.8 Төсвийн төсөлд тусгасан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлтийг Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлэх, сонгох, эрэмбэлэх үйл ажиллагааны журам болон аргачлалууд”-ын дагуу 16 шалгуур үзүүлэлтээр цахим системд төлөвлөн, эдийн засгийн болон нийгмийн ач холбогдлоор нь эрэмбэлж төлөвлөсөн байна.

2.9 УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсыг 2021-2025 хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл болон түүний хавсралтаар баталсан “Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-т зааснаар 2023 онд улсын төсвөөр нийт 20 төсөл, хөтөлбөрийг 754.5 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөснөөс 12 төсөл, хөтөлбөрийн 356.8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг улсын төсвөөс олгохоор төлөвлөж, эх үүсвэрийг Монгол Улсын 2023 оны төсвийн төсөлд тусгаагүй байна. Тухайлбал,

- Үндэсний урлагийн их театрын барилгыг 2021-2023 онд барихаар төлөвлөснөөс 2023 онд 50.8 тэрбум төгрөгөөр санхүүжих;
- 90МВт-ын хүчин чадалтай Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцыг 2018-2024 онд барих, 2023 онд 12.4 тэрбум төгрөгөөр санхүүжих;
- Улаанбаатар хотын ус хангамжийг урт хугацаанд тогтвортойгоор нэмэгдүүлэх төслийг 2021-2025 онд хэрэгжүүлэх, 2023 онд 89.1 тэрбум төгрөгөөр санхүүжих;
- Цагдаагийн байгууллагын хэт богино долгионы радио холбооны шинэчлэл хийх төслийг 2021-2024 онд хэрэгжүүлэх, 2023 онд 25.0 тэрбум төгрөгөөр санхүүжих;
- Цагдаагийн байгууллагын авто парк шинэчлэл хийх төслийг 2021-2024 онд хэрэгжүүлэх, 2023 онд 10.0 тэрбум төгрөгөөр санхүүжих;
- Концессын “барих-шилжүүлэх” төрлөөр байгуулсан гэрээний хэрэгжилт хугацаандаа хангаагдаагүйгээс 2 төслийн 132.4 тэрбум төгрөгийн санхүүжилт хуульд тусгаагдаагүй байна.

2.10 Дээрх төсөл, хөтөлбөрийн ихэнх нь гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байх тул эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл, төсөл, хөтөлбөрийн хэрэгцээ шаардлагатай уялдуулан хөтөлбөрт өөрчлөлт оруулах нь зүйтэй байна.

2.11 Төсвийн төсөлд шинээр эхлүүлэхээр төлөвлөсөн 5 төсөл, арга хэмжээ нь Хөгжлийн урт болон дунд хугацааны бодлоготой нийцсэн бөгөөд тухайн жилд хэрэгжиж дуусах хугацаатай тул Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5-т заасан “Шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох хэсэг нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож тусгах” шалгуурыг бүрэн хангасан байна.



Хүснэгт 2 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээ, тэрбум төгрөг

Хуулийн дугаар	ТАХ-ний нэр, хүчин чадал, байршил	ТЭЗ	Хугацаа		Төсөвт өртөг	Санхүүжих дүн
			Эхлэх	Дуусах		
VI.2.4.1	Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-ний ТЭЗҮ, зураг төсөө, зөвлөх үйлчилгээ, бэлтгэл хангалт /Улсын хэмжээнд/	CaC	2023	2023	80.0	80.0
XII.1.2.7	Улсын чанартай хатуу хучилттай авто замын их засвар /Өмнөговь, Дундговь, Өвөрхангай, Баянхонгор, Төв, Хэнтий/	ЗТХС	2023	2023	35.6	35.6
XVIII.3.1	Үндэсний дата төвийн тоног төхөөрөмж, техникийн хүчин чадлыг сайжруулах төсөл /УБ, СХД/	ЦХХХС	2023	2023	13.6	13.6
XX.1.1	Нийтийн тээврийн автопарк /УБ, СХД/	УБ хотын автозамын түгжрэлийг бууруулах ҮХД	2023	2023	21.7	21.7
XX.3.1	Нийтийн тээврийн автобус /УБ/		2023	2023	318.0	318.0
<b>НИЙТ ДҮН</b>					<b>468.9</b>	<b>468.9</b>

Эх сурвалж: Сангийн яам, ЗТХЯ, Монгол Улсын 2023 оны төсвийн төсөл

2.12 Шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн Нийтийн тээврийн автопарк байгуулах, автобус худалдан авах төсөл, арга хэмжээ нь хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд дараах байдлаар тусгагдсан байна.

- УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 9.3.4-т “олон төрөлт, ухаалаг нийтийн тээвэр хэрэглээнд нэвтэрсэн байна”
- 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 6.1.д Улаанбаатар хотын замын хөдөлгөөний нягтралыг сарниулж, ачааллыг тэнцвэржүүлсэн, тээврийн эрэлтэд нийцсэн авто замын сүлжээг бий болгож, түгжрэлийг бууруулна.
- УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 9.3.1-д Улаанбаатар хотын төвлөрөл, суурьшсан нутаг дэвсгэрийн тэлэлт, хязгаарлалт, газар зохион байгуулалт, авто замын сүлжээ, нийтийн тээвэр, газар доорх орон зай гэх мэт шаардлагатай төлөвлөлтийг тооцон хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, мэдээллийн нэгдсэн системд холбон хот байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. II үе шат (2031-2040): Хотын экосистемийн тэнцвэрт байдлыг хангасан ногоон, ухаалаг технологийн үеийн 4-т Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилгоор нийтийн тээвэрт эко, цахилгаан тээврийг нэвтрүүлсэн байна гэж тус тус заасан байна.

2.13 Засгийн газрын 2021 оны 146 дугаар тогтоолд Нийслэл Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулахад чиглэсэн төсөл, арга хэмжээнд жил бүр 420.0 тэрбум төгрөгөөс доошгүй санхүүжилтийн эх үүсвэрийг улсын төсвийн төсөлд тусгаж, шийдвэрлүүлж байхаар заасныг үндэслэн 2023 оны төсвийн төсөлд нийт 339.7 тэрбум төгрөгийг төсөвлөж, түүний дотор цахилгаан хөдөлгүүртэй автобус 350 ширхэг, цэнэглэх төхөөрөмж 50 ширхгийг худалдан авахад нийт 279.2 тэрбум төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн нь дээрх бодлогын баримт бичигт заасан хугацаатай нийцэхгүй ба бэлтгэл ажлын зардал хэрхэн туссан, цахилгаан автобус цэнэглэх цэгүүдийн байршил, суурилуулалтын ажлыг хэрхэн хийх нь тодорхойгүй байна.

2.14 Манай улсын өнөөгийн нөхцөлд цахилгаан автобусыг ашиглах талаар туршилт, судалгаа хийсэн эсэх нь тодорхойгүй, MNS6224:2010 нийтийн үйлчилгээний цахилгаан тээврийн хэрэгсэл угсрах үйлдвэрлэлд тавих ерөнхий шаардлага, MNS6225:2010 нийтийн үйлчилгээний тээврийн JEA-800F загварын автобус техникийн шаардлага гэсэн 2 стандартыг мөрдөж байна. Харин худалдан авахаар төлөвлөсөн цахилгаан автобусны талаар стандарт, журам байхгүй, парк болон цэнэглэгч станцуудыг хаана байрлуулах нь



тодорхойгүй байгаа нь төсөл, арга хэмжээний хэрэгжилтээр бий болох үр дүнг сааруулж болзошгүй байна.

Хүснэгт 3 Улаанбаатар хотын нийтийн тээврийн парк шинэчлэлийн хүрээнд худалдан авалт хийх төсөв, тоо ширхэг, сая төгрөг


Нэр төрөл	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
Дизель хөдөлгүүртэй стандарт автобус	57	429.5	24,480.4
Дизель хөдөлгүүртэй дунд оврын автобус	50	286.3	14,316.0
Цахилгаан хөдөлгүүртэй автобус	350	787.4	275,583.0
Цэнэглэх төхөөрөмж	50	72.1	3,605.8
<b>НИЙТ ДҮН</b>			<b>317,985.2</b>

Эх сурвалж: Монгол Улсын 2023 оны төсвийн төсөл

2.15 Дизель хөдөлгүүртэй 107 ширхэг автобус худалдан авахаар төлөвлөсөн бөгөөд төсвийн саналыг боловсруулахдаа тухайн автобусанд тавигдах шаардлага, төсөв хэмнэх, үр ашгийг хэрхэн сайжруулах боломж, агаар орчны бохирдлыг хэрхэн бууруулах нөхцөл шаардлагыг тодорхойлоогүй байна. Иймд олон улсад тавигдаж буй шаардлагын дагуу Евро-5 стандарт хангасан автобус худалдан авах хэрэгтэй байна.

2.16 Сүүлийн таван жилийн хугацаанд Монгол Улс Тогтвортой хөгжлийн зорилгын индексээр 14 байр ухарсан байна (Зураг 1) “Чанартай боловсролыг дэмжих” зорилтын гүйцэтгэлийг ТХЗ-ын биелэлтийг хэрэгжүүлж байгаа буюу өмнөх үр дүнгээ хэвээр хадгалсан гэж ангилсан бол 9 зорилтын хүрээнд сорилт тулгарсан хэвээр байна. ТХЗ 10 “Тэгш бус байдлыг бууруулах” болон ТХЗ 13 “Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах” зорилтуудын биелэлт буурах хандлагатай байгааг анхаарах шаардлагатай байна.

Зураг 1 2018-2022 оны ТХЗ-ын индекс болон 2022 оны зорилтуудын өөрчлөлт



Эх сурвалж: <https://dashboards.sdgindex.org/profiles/mongolia>



## ГУРАВ. ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙГ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЭХГҮЙ БАЙНА

### **Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан тусгай шаардлагыг хангаж байна**

3.1 Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн төслийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага, 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлж төлөвлөсөн эсэхэд дараах дүгнэлт гаргаж байна.

*Хүснэгт 4 Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагыг хангасан эсэх*

№	Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага	Төсвийн төсөлд тусгасан байдал	Тусгай шаардлага хангасан байдал
1	6 дугаар зүйл: 6.1.1. “нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцсон байх”	Зэс, нүүрсний үнийг тэнцвэржүүлсэн журмаар 2023 онд зэсийн тэнцвэржүүлсэн үнийг тонн тутамд 8,386.7 ам.доллар, нүүрсний тэнцвэржүүлсэн үнийг тонн тутамд 110.8 ам.доллар байхаар тооцсон байна.	Аудитын баг давтан тооцоолол хийж баталгаажуулсан бөгөөд хуульд заасан тусгай шаардлагыг хангасан байна.
2	6 дугаар зүйл: 6.1.2. “нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байх”, 19 дүгээр зүйлийн 19.9-т “... 2022 онд 5.1 хувиас, 2023 онд 3.6 хувиас, ... тус тус хэтрүүлэхгүй,	Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл - 1,553.4 тэрбум төгрөг буюу ДНБ-ий -2.8 хувьтай тэнцэхээр төлөвлөсөн байна.	Хуульд заасан тусгай шаардлагыг хангасан байна.
3	6 дугаар зүйл: 6.1.3. тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хувь, тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн дунджийн аль ихээс хэтрэхгүй байх;	Тухайн жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлт 11.0 хувь, 2011-2022 оны эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн дундаж 14.6 хувьтай тус тус тэнцэж байна. 2023 оны төсвийн төсөлд нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлт 14.3 хувь байхаар тусгасан байна.	Хуульд заасан тусгай шаардлагыг хангасан байна.
4	6 дугаар зүйл: 6.1.4. “Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон ДНБ-ий 60 хувиас хэтрэхгүй байх”, 19 дүгээр зүйлийн 19.3-т “Энэ хуулийн 6.1.4-т ... 2022 оны төсвийн жилд 70 хувиас, 2023 оны төсвийн жилд 65 хувиас, 2024 оны төсвийн жилээс эхлэн 60 хувиас тус тус хэтрүүлэхгүй байна”	Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдлийг ДНБ-д харьцуулсан харьцаа нь 65.0 байхаар тусгасан.	Хуульд заасан тусгай шаардлагыг хангасан байна.



3.2 Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д "Төсвийн төслийг боловсруулахад Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шаардлагаас гадна дараах шаардлага тавигдана" гэж заасан хэдий ч УИХ-д өргөн мэдүүлсэн төсвийн төсөл дараах заалтад нийцээгүй байна. Үүнд:

**27.1.4.жилийн төсвийн хязгаарт үндэслэсэн байх;**

- Төсвийн төслийг боловсруулахдаа Засгийн газрын 2022 оны 258 дугаар тогтоолоор баталсан төсвийн орлогын доод хязгаар, төсвийн зарлагын дээд хязгаарт нийцүүлээгүй байна. Тухайлбал:

**Хүснэгт 5 Төсвийн хязгаарыг баримталсан байдал**

№	Үзүүлэлт	Төсвийн хязгаараас нэмэгдүүлсэн		Төсвийн хязгаараас бууруулсан	
		ТЕЗ-ийн тоо	Мөнгөн дүн	ТЕЗ-ийн тоо	Мөнгөн дүн
1	Төсвийн орлого	-	-	6	-30,334.6
2	Төсвийн зарлага	29	3,470,464.7	-	-

Эх сурвалж: Сангийн яам, ЗТХЯ, Монгол Улсын 2023 оны төсвийн төсөл

3.3 Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.9-д төсвийн төсөл "төрийн мөнгөний бодлогын зорилтод нийцсэн байх" гэж заасан бөгөөд төсвийн төслийн танилцуулгад "Цар тахлын болон геополитикийн хямралын үеийн эдийн засгийг тогтворжуулахад чиглэсэн төсөв, мөнгөний бодлогыг баримтална" гэж тусгасан хэдий ч УИХ-аас "Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэл"-ийг эцэслэн батлаагүй, Монголбанк төслийг 2022 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн байна.

3.4 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.5<sup>5</sup> дахь заалт, Төв Банк /Монголбанк/-ны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2<sup>6</sup> дахь хэсэгт төсвийн төсөл болон төрийн мөнгөний бодлогыг 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор УИХ-д өргөн мэдүүлэхээр тусгасан бөгөөд сүүлийн 5 жилийн байдлаар зөвхөн 2021 онд Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлийг баталсны дараа улсын төсвийг баталж иржээ.

**Хүснэгт 6 Улсын төсөв болон төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлийн баталсан байдал**

№	Үзүүлэлт	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он
		Баталсан огноо				
1	Монгол Улсын нэгдсэн төсөв	2017.11.14	2018.11.02	2019.11.13	2020.11.13	2021.11.12
2	Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл	2017.11.16	2018.11.15	2019.12.05	2020.11.05	2021.11.18

Эх сурвалж: <https://legalinfo.mn>

3.5 Төсвийн танилцуулгад төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ, түүнд шаардагдах орц, хүрэх үр дүн, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тусгасан хэдий ч тэдгээртэй холбогдсон тайлбар, танилцуулгыг иж бүрэн тусгаагүй нь Төсвийн тухай хуулийн 32.2.11-д "... хөтөлбөр, арга хэмжээ, түүнд шаардагдах орц, хүрэх үр дүн, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, тэдгээртэй холбогдсон тайлбар, танилцуулга" гэж заасантай нийцээгүй байна.

**Төсвийн хүрээний мэдэгдлийг төсвийн төсөлд нийцүүлэн өөрчилдөг дутагдал давтагдаж байна**

3.6 Засгийн газар нь УИХ-аас 2022 оны 5 дугаар сарын 27-ны өдөр баталсан "Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн

<sup>5</sup> Төсвийн тухай хууль 8.4.5.Засгийн газар жилийн төсвийн төслийг жил бүрийн 10 дугаар сарын 01-ний дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

<sup>6</sup> Төв Банк /Монголбанк/-ны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2. Монголбанк дараагийн жилд баримтлах төрийн мөнгөний бодлогыг боловсруулж, жил бүрийн 10 дугаар сарын 1-ний дотор Улсын Их Хуралд өргөн барих бөгөөд түүнд дараахь асуудлыг тусгасан байна:



тухай” хуульд дараах өөрчлөлт оруулах тухай төслийг 2023 оны төсвийн төслийн хамт өргөн мэдүүлсэн байна./Дэлгэрэнгүйг Хавсралт 3-с үзнэ үү/ Үүнд:

- Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 1,609.7 тэрбум төгрөгөөр,
- Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээг 1,256.2 тэрбум төгрөгөөр,
- Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээг 1,256.2 тэрбум төгрөгөөр,
- Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээг 862.9 тэрбум төгрөгөөр,
- Засгийн газрын өрийн нийт хэмжээг өнөөгийн үнэ цэнээр 1,006.1 тэрбум төгрөгөөр,
- Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээг 1,394.2 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлж,
- Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 353.4 тэрбум төгрөгөөр бууруулсан байна.

3.7 Засгийн газар 2023 оны төсвийн төслийг боловсруулахдаа Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1<sup>7</sup>-д заасан зарчмыг баримтлаагүй, төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулах хуулийн төслийн хамт УИХ-д өргөн мэдүүлсэн нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3<sup>8</sup> дахь хэсэг, 10 дугаар зүйлийн 10.1.3<sup>9</sup>, 11 дүгээр зүйлийн 11.1.2<sup>10</sup> дахь заалттай тус тус нийцэхгүй байна.

## **ДӨРӨВ. ТӨСВИЙН ОРЛОГЫГ НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖ БАЙНА**

4.1 Төсвийн төсөлд Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд дэвшүүлсэн Боомтын сэргэлтийн ажлыг эрчимжүүлж, экспортыг нэмэгдүүлэх, ашигт малтмалын орд газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах, далд эдийн засгийг бууруулж, татварын суурийг нэмэгдүүлэх бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлснээр нийт орлого ба тусламжийн дүнг 19,594.6 тэрбум, тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийг 18,921.9 тэрбум төгрөг байхаар төлөвлөсний 90.2 хувийг татварын орлогоос, 9.8 хувийг татварын бус орлогоос бүрдүүлэхээр тооцжээ.

4.2 Геополитикийн хямралт нөхцөл байдал болон дэлхийн эдийн засгийн өсөлт саарснаас инфляц өсөж, улс орнуудын төв банк мөнгөний хатуу бодлого хэрэгжүүлэх болсон зэргээс шалтгаалж экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүн болох зэс, алт, төмрийн хүдрийн үнэ буурах төлөвтэй байгаа нь ирэх оны төсвийн орлого бүрдэлтэд эрсдэл учруулж болзошгүй байна.

4.3 Уул уурхайн бүтээгдэхүүнд илүү найдсан төлөвлөлт хэвээр байгаа тул бусад салбарын орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлж, орлогыг бодитой төлөвлөх шаардлагатай байна.

4.4 Нүүрсний борлуулалтын биет хэмжээг 2021 оны гүйцэтгэлээс 20.3 сая тонн, 2022 оны төлөвлөгөөнөөс 18.5 сая тонноор нэмэгдүүлэн өөдрөгөөр тооцсон байна.

4.5 Төсвийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд АМНАТ-өөс Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу Төсвийн тогтворжуулалтын санд хуваарилаад үлдэх хэсгээс Ирээдүйн өв санд хуваарилах хувь 2023 онд 0 (тэг) байхаар заасан байна. Иймд АМНАТ-ийн 2,515.1 тэрбум төгрөгийн орлогоос Тогтворжуулалтын санд 109.2 тэрбум төгрөг хуваарилж, Ирээдүйн өв санд орлого төвлөрүүлэхгүйгээр тооцсон байна.

<sup>7</sup> Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1-д төсвийн тогтвортой байдлыг хангасан байх

<sup>8</sup> Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-д “Төсвийн төсөл боловсруулах, батлах, батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулахдаа дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлнэ

<sup>9</sup> Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3-д төсвийн төсөл болон батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулахдаа дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэх санал боловсруулахдаа төсвийн тусгай шаардлага, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг баримтлах

<sup>10</sup> Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2-т “төсвийн төсөл болон батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах



4.6 Төсвийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн УИХ-ын тогтоолын 2.7-д заасныг “Уул уурхайн салбарт ашигт малтмалын лиценз эзэмшигч төрийн болон төрийн өмчийн оролцоот хуулийн этгээдийн жилийн эцсийн санхүүгийн тайлангаар гарсан цэвэр ашгийн 60 хувь болон төрийн эзэмшилд хамаарах эздийн өмчийн 2 хувьтай тэнцэх дүнгийн аль өндөр дүнгээр, бусад төрийн болон төрийн өмчийн оролцоот хуулийн этгээдийн жилийн эцсийн санхүүгийн тайлангаар гарсан цэвэр ашгийн 50 хувь болон төрийн эзэмшилд хамаарах эздийн өмч нь 2.0 тэрбум төгрөгөөс дээш бол 2 хувиар, 2.0 тэрбум төгрөгөөс доош бол 1 хувиар тооцон хуваарилж төсөвт төвлөрүүлэх арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд чиглэл болгон ажиллах” гэж өөрчилснөөр орлогыг 192.4 тэрбум төгрөг (Ирээдүйн өв сан 184.4 тэрбум, улсын төсөв 8.0 тэрбум төгрөг) нэмэгдүүлэх боломж байна.

4.7 Тогтворжуулалтын сангийн 2023 оны орлогыг 132.7 тэрбум төгрөг буюу 2022 оны тодотгосон төсвөөс 619.0 тэрбум төгрөгөөр бууруулж төлөвлөсөн нь тайлант онд алт, төмрийн хүдэр, боловсруулаагүй нефть зэрэг эрдэс баялгийн үнэ дэлхийн зах зээлд буурна гэж тооцоолсонтой холбоотой байна.

4.8 Аудитын хүрээнд “Эрдэнэтийн овоо зэс-молибдений орд”-ын нөөцийн тайлан болон “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын экспортод гаргаж буй баяжмалд агуулагдаж буй дагалдах ашигт малтмалын нэр төрөл, агуулга, тоо хэмжээг тодорхойлж, эдийн засгийн үр ашигт дүн шинжилгээ хийсэн болно.

4.9 Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын молибдений баяжмалд хийсэн Гаалийн төв лабораторийн магадлан шинжилгээний дүгнэлтээс үзэхэд “... тус баяжмалд молибден 51.16%, зэс 1.74%, мөнгө 34.47мг/кг, хөнгөн цагаан 2.31%, төмөр 3.38%, цахиурын оксид 1.58%, рени 467.4мг/кг, торгуулийн элемент болох мышьяк 201.3 мг/кг, фосфор 116.5 мг/кг тус тус агуулагдаж байна”<sup>11</sup> гэж тогтоосон хэдий ч 2016-2021 оны ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тайлангаас үзэхэд зөвхөн зэс, молибден, мөнгөнд АМНАТ ногдуулсан байна.

4.10 Баяжмалд агуулагдаж буй дээрх дагалдах ашигт малтмалаас эдийн засгийн ач холбогдол бүхий Рени (Re)-д үр ашгийн тооцоолол хийж үзэхэд тус үйлдвэр жилд борлуулалтын орлогыг 14.5 тэрбум төгрөгөөр, улсын төсөвт төвлөрүүлэх АМНАТ-ийг 729.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой гэсэн тойм үнэлгээ гарч байна.

Хүснэгт 7 Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын молибдений баяжмал дахь дагалдах бүрдвэр ренийн эдийн засгийн үнэлгээ /урьдчилсан тойм/

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Тоон үзүүлэлт
1	Үйлдвэрлэх Молибденийн баяжмал	тн	310,700.0
2	Үйлдвэрийн ажиллах хугацаа	жил	46
3	Жилд гаргах баяжмалын хэмжээ	тн	6,754.35
4	1 тн баяжмал дахь Рени /Re/-ийн агуулга	гр/тн	450.0
5	Жилд гаргах Рени /Re/	кг	3,039.5
6	Рени /Re/-ийн зах зээлийн үнэ	ам.доллар	1,500.0
7	Валютын ханш	төгрөг/ам.доллар	3,200.0
8	Жилийн борлуулалтын хэмжээ	сая.төгрөг	14,589.4
9	Ногдуулах АМНАТ	сая.төгрөг	729.5

Эх сурвалж: Шинжээчийн ажлын тайлан

4.11 Энэ нь уул уурхайн салбарын экспортын бүтээгдэхүүнээс улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг нэмэгдүүлэх нөөц боломж байгаа төдийгүй татварын орлогын гүйцэтгэлийг

<sup>11</sup> Эх сурвалж: Гаалийн төв лабораторийн 2022.04.29-ний өдрийн №0122002651 дугаар магадлан шинжилгээний дүгнэлт



татварын төрөл, татвар төлөгч ААН, байгууллага, төлсөн татвар тус бүрээр хянах замаар татварын орлогыг бодитой төлөвлөх шаардлагатай гэдгийг харуулж байна.

4.12 Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлд “Татварын алба нь энэ хуульд зааснаас бусад үндэслэлээр татвар төлөгчийн мэдээллийг бусдад өгөх ... байдлаар задруулахыг хориглоно” гэж заасан тул төрийн аудитын байгууллага татварын орлогын гүйцэтгэл /татварын төрөл, татвар төлөгч ААН, байгууллага, төлсөн татвар тус бүрээр/-тэй танилцах боломжгүй<sup>12</sup> байна. Үүнээс шалтгаалан улсын төсвийн орлогыг Төсвийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, Ашигт малтмалын тухай хуульд заасны дагуу тооцож, төлөвлөж буй эсэхийг үнэлэх, дүн шинжилгээ хийх боломж хязгаарлагдаж байна.

4.13 Иймд Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т заасан бүрэн эрхийн хүрээнд төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх талаар дүгнэлт гаргах зорилгоор татварын орлогын төлөвлөлт, гүйцэтгэлтэй иж бүрэн танилцаж, дүн шинжилгээ хийх эрх зүйн зохицуулалтыг Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т нэмэлтээр тусгах шаардлагатай байна.

### **Төсвийн урсгал зардлыг бууруулах боломжтой байна**

4.14 Засгийн газрын 2022 оны “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2023 оны төсвийн хязгаарыг батлах тухай” 258 дугаар тогтоолоор баталсан урсгал зардлын хязгаараас гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн тогтолцоонд шилжсэн БШУС, ЭМС болон шинээр байгуулагдсан 4 сайдын багцаас бусад 27 төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төслийг 481.9 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж төсөвлөсөн байна.

4.15 “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрт шаардагдах зээлийн эх үүсвэр шийдэгдээгүй байгаа нь хэрэгжилтэд хүндрэл учрах эрсдэлтэй байна.

4.16 Цар тахлын үед иргэдийн амьжиргаа өрхийн орлогыг нэмэгдүүлэх бодлогын хүрээнд Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийг үндэслэн хүүхдийн мөнгөн тэтгэмжийг 100.0 мянган төгрөг болгон нэмэгдүүлсэн. Харин цар тахлын үеийн нөхцөл байдал хэвийн хэмжээнд хүрч уг хууль болон Засгийн газрын тогтоолын үйлчлэх хүрээ 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болж байгаа тул хүүхдийн мөнгөн тэтгэмжийг судалгаа, тооцоонд үндэслэн зохистой хэмжээнд бууруулах нөхцөл бүрдсэн байна.

4.17 Төсвийн төсөлд томилолт, зочны зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 2022 оны батлагдсан төсвөөс 131.8 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

4.18 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, 3.1.4-т зааснаас бусад этгээд үйл ажиллагааны санхүүгийн сахилга бат, хэмнэлтийн талаар хэрхэн тайлагнах, ил тод мэдээлэх, хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг ямар албан тушаалтан, ямар хариуцлага хүлээлгэх нь тодорхойгүй байна.

4.19 Төсвийн төсөлд Нийгмийн даатгалын сангийн орлогыг 3,739.3 тэрбум төгрөг байхаар төсөвлөснөөс шимтгэлийн орлого 3,185.1 тэрбум төгрөг, төр хариуцах иргэдийн тэтгэвэр, шимтгэлийн орлого 545.2 тэрбум төгрөг, бусад орлого 8.9 тэрбум төгрөг байна. Харин нийгмийн даатгалын зарлага 3,748.0 тэрбум төгрөг, арилжааны банкнаас авах авлагыг 68.3 тэрбум төгрөг байхаар төсөвлөжээ.

<sup>12</sup> Татварын ерөнхий газрын 2022 оны 9 дүгээр сарын 19-ний өдрийн 01/2041 дүгээр албан бичиг





4.20 Нийгмийн халамжийн арга хэмжээнд 2018 онд 623.8 тэрбум, 2019 онд 671.0 тэрбум, 2020 онд 1,586.9 тэрбум, 2021 онд 1,973.7 тэрбум төгрөг зарцуулсан бол 2022 онд 1,944.6 тэрбум төгрөгийг төсөвлөсөн байна. Төсвийн төсөлд 1,991.4 тэрбум төгрөгөөр тусгасан нь ДНБ-ний 4.1 хувь, урсгал төсвийн зардлын 14.0 хувийг тус тус эзэлж, төсөвт учруулах ачаалал нэмэгдэж байна.

4.21 Гадаад зээл, тусламжийн санхүүжилтээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөв Сангийн сайдын багцад тусгасан ч төсөл хэрэгжүүлэгч байгууллага, төсвийн ерөнхийлөн захирагч нь төслийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих чиг үүргээ нэмэгдүүлж ажиллах шаардлагатай байна.

4.22 Гадаад зээл, тусламжийн санхүүжилтээс төслийн нэгжийн урсгал зардалд зарцуулж байгаа санхүүжилтийг хэмнэх үүднээс тухайн салбарт хэрэгжиж буй төслүүдийн нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийг байгуулж, орон тоог цөөлөх, зардал хэмнэх арга хэмжээг авах шаардлагатай байна.

4.23 Засгийн газрын өрийн баталгаатай Монгол Улсын Хөгжлийн банк, Эрдэнэс Монгол ХХК-иуд байна. Засгийн газрын 2021 оны 311, 2022 оны 160 дугаар тогтоолоор Оросын Холбооны Улсын “Роснефт НХН”-ээс АИ-92 автобензин худалдан авах зориулалтаар тухайн онд эргэн төлөгдөх нөхцөлтэй Засгийн газрын баталгааг шатахуун импортлогч 8 байгууллагад гаргасан байна.

4.24 Засгийн газраас 2023 онд “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл хөтөлбөрүүдэд олгох 1.0 тэрбум ам.доллартой тэнцэх өрийн баталгаа гаргах тохиолдолд Өрийн удирдлагын тухай хуульд заасны дагуу эрсдэлийн үнэлгээг хийж, болзошгүй өр төлбөрийн эрсдэлээс сэргийлэх шаардлагатай байна.

4.25 Монгол Улсын Засгийн газар Хөгжлийн түнш улс, олон улсын байгууллагаас 2023 онд нийт 1,574.5 тэрбум төгрөгийн гадаад зээл авч ашиглахаар төлөвлөж, зээлийн үндсэн төлбөрт 1,157.0 тэрбум төгрөгийг төлж, зээлийн цэвэр ашиглалт 417.5 тэрбум төгрөг байгаа нь цаашид төлбөрийн тэнцэлд дарамт учруулах эрсдэлтэй байна.

4.26 Засгийн газар 2023 онд Өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичигт заасны дагуу гадаад үнэт цаасны өрийн зохицуулалтын арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, гадаад үнэт цаасны үндсэн төлбөрт 465.7 тэрбум төгрөг төлөхөөр төлөвлөсөн байна.

4.27 Сангийн сайдын 2022 оны 7 дугаар сарын 06-ны өдрийн 145 дугаар тушаалын дагуу Засгийн газрын өрийн оновчтой багцын бүтцийг бий болгох, Засгийн газрын санхүүжилтийн хэрэгцээг бага зардлаар, боломжит эрсдэлийн түвшинд хангах зорилгоор 300.0 тэрбум төгрөгтэй тэнцэх Засгийн газрын дотоод үнэт цаасыг 2022 оны 7 дугаар сард “Хадгаламжийн даатгалын корпораци сан”-д арилжаалсан байна.

4.28 Төсвийн төсөлд 2,606.4 тэрбум төгрөгийн Засгийн газрын дотоод үнэт цаас шинээр гаргахаар төлөвлөсөн нь Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичигтэй нийцэж байна.

4.29 Нийт зарлага ба цэвэр зээлийн дүнд урсгал зардлын эзлэх хувь өмнөх 5 жилийн гүйцэтгэлээр дунджаар 77.5 хувьтай байсан бол төсвийн төсөлд 74.5 хувьтай буюу өмнөх 5 жилийн гүйцэтгэлээс 3.0 хувиар бууруулж төсөвлөсөн байна. Харин нийт зарлага ба цэвэр зээлийн дүнд хөрөнгийн зардлын эзлэх хувь 5 жилийн гүйцэтгэлээр дунджаар 20.6 хувьтай байсан бол 2023 онд 26.1 хувь болж 5.5 хувиар нэмэгдсэн байна.



Хүснэгт 8 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын зардлын нийт хөрөнгийн зардалд эзлэх хувь

АНГИЛАЛ	2017	2018	2019	2020	2021	2022	2023
	гүйц	гүйц	гүйц	гүйц	гүйц	Тод 2	Төсөл
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	7,958.3	10,172.8	12,040.3	10,444.2	14,306.4	16,278.1	19,594.6
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,017.3	9,317.2	11,661.7	13,904.3	15,630.4	17,913.5	20,475.3
Урсгал зардал	7,043.2	7,350.3	8,228.6	10,828.9	12,804.0	13,881.8	15,259.9
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүнд урсгал зардлын эзлэх хувь	78.1	78.9	70.6	77.9	81.9	77.5	74.5
Хөрөнгийн зардал	1,658.1	1,680.4	3,016.7	3,034.2	2,982.2	4,296.3	5,347.3
Үүнээс, улсын төсвийн хөрөнгө оруулалтын	715.7	659.4	1,559.9	1,414.6	1,577.7	1,697.4	2,981.7
УТХО-ын нийт хөрөнгийн зардалд эзлэх хувь	43.2	39.2	51.7	46.6	52.9	39.5	55.8

Эх сурвалж: Сангийн яам


4.30 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээний тоог 2022 онтой харьцуулахад 311-ээр бууруулсан боловч төсөвт өртгийн дүнг 437.5 тэрбум төгрөгөөр, тухайн жилд санхүүжих дүнг 1,284.4 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.

4.31 Монгол Улсын 2023 оны төсвийн төсөлд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шилжих 6,516.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1056 төсөл, арга хэмжээг 2,233.2 тэрбум төгрөгөөр, шинээр 468.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 5 төсөл арга хэмжээг бүрэн санхүүжүүлж, нийт 6,985.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1061 төсөл, арга хэмжээг 2,702.1 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна. Концессын “барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжсэн 541.5 тэрбум төгрөгийн гэрээний үнэ бүхий 4 төсөл, арга хэмжээний хөрөнгө оруулалтын эргэн төлөлтөд 279.6 тэрбум төгрөг олгохоор тусгажээ.

4.32 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын сүүлийн 7 жилд хэрэгжилтийг баталж, санхүүжүүлсэн шинэ, шилжих төсөл, арга хэмжээний тоо, төсөвт өртгийн өсөлт өмнөх жилтэй харьцуулахад дунджаар 20.1 хувиар өсөж дараагийн жилд шаардагдах төсвийг нэмэгдүүлж байна. Энэ нь тухайн жилд санхүүжих дүнг багаар баталдагтай холбоотой бөгөөд төсөл, арга хэмжээний хэрэгжих хугацаа уртсах, улмаар төсөвт өртөг нэмэгдэх нөхцөлийг бүрдүүлж байна.




График 1. Шинэ, шилжих төсөл, арга хэмжээний өсөлт, сая төгрөг



Эх сурвалж: Сангийн яам

График 2. Дараа онд шилжсэн дүн, сая төгрөг



Эх сурвалж: Сангийн яам

4.33 Монгол Улсын 2023 оны төсвийн төсөлд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар өмнөх оноос шилжин хэрэгжиж буй төсөл, арга хэмжээг дуусгах чиглэлийг баримталсан нь хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, эдийн засгийн өсөлтийг дэмжсэн арга хэмжээ болсон байна.

4.34 Үндэсний аудитын газраас 2022 онд гүйцэтгэсэн “Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн аудитаар төсвийн хөрөнгөөр 2008-2020 онд хэрэгжүүлж эхэлсэн нийт 184.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 59 төсөл, арга хэмжээг 85.0 тэрбум төгрөгөөр санхүүжүүлээд орхисон бол эдгээр төсөл, арга хэмжээний тоо нэмэгдэж, 2022 оны 10 дугаар сарын байдлаар 201.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 61 төсөл, арга хэмжээнд 88.8 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон дүнтэй байна. (Дэлгэрэнгүйг хавсралт 1-ээс харна уу)

4.35 Аудитын явцад хийсэн судалгаагаар илэрсэн орхигдсон эдгээр 61 барилга, байгууламжийн ихэнхийг буюу 32.8 хувийг цахилгаан, дулааны инженерийн байгууламж



эзэлж байна. төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг хэрэгцээ шаардлагад нийцүүлэн төлөвлөөгүй, хэрэгжилтийн явцад тавих захиалагч, зохиогчийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй, төлөвлөлтийн үе шатнаас эхлэн ашиглалтын хугацаа дуусах хүртэлх хугацаанд хяналт тавих нэгдсэн систем, цахим сан байхгүйгээс төсөл, арга хэмжээ дутуу орхигдох, хаягдах, зарцуулсан хөрөнгө үргүйдэх байдал ажиглагдаж байна.

4.36 Иймд улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр барих барилга, байгууламжийн төсөл, арга хэмжээг бүртгэлжүүлж, кодлох, түүгээр дамжуулан бүтээн байгуулах, ашиглах бүхий л хугацаанд нэгдсэн хяналтын тогтолцоо бүрдүүлж, зах зээлийн чадамжид суурилан төлөвлөх, суурь судалгааг иж бүрэн хийж төсөвлөлтөд ашиглах нь үр дүнтэй байна.

4.37 Аудитын явцад хийсэн судалгаагаар 2023 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн 74.8 хувийг барилга угсралтын ажлын гүйцэтгэлд зарцуулахаар төсөвлөсөн бөгөөд Монгол Улсын барилгын салбарын хүчин чадлыг гарцаар буюу сүүлийн 10 жилийн гүйцэтгэлээр тооцож үзвэл, нийт бүтээн байгуулалтын ажлын 97.7 хувийг хувийн хэвшил гүйцэтгэж, жилд дунджаар 4,050.4 тэрбум<sup>13</sup> төгрөгийн төсөвт өртөг бүхий барилга угсралтын ажил гүйцэтгэх чадамжтай байна.

4.38 Улсын хэмжээний тоон мэдээллээс харахад 2018 онд хамгийн их буюу нийт гүйцэтгэсэн барилга угсралтын ажлын 94.1 хувь (4,050.4 тэрбум төгрөгийн өртөгтэй) нь ашиглалтад орсон байна.

Хүснэгт 9 Улсын хэмжээнд ашиглалтад оруулсан үндсэн фонд (тэрбум төгрөг, хувь)

Статистик үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021
Барилга угсралт, их засварын ажил	1,034.1	1,845.9	2,702.9	3,267.4	3,356.3	3,783.6	4,305.6	4,869.8	5,208.8	4,513.2
Ашиглалтад оруулсан төсөвт өртөг	895.7	1,564.7	1,479.4	1,965.1	2,744.9	2,572.9	4,050.4	3,594.9	2,761.2	2,689.2
Ашиглалтад орсон хувь	86.6	84.8	54.7	60.1	81.8	68.0	94.1	73.8	53.0	59.6

Эх сурвалж: www.1212.mn

4.39 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барих барилга байгууламжийн ажил барилгын салбарын чадавх дунджаар 71.7 хувийг эзэлж байх тул эдийн засаг, санхүүгийн цар хүрээ хязгаарлагдмал, гадаад хүчин зүйлээс ихээхэн хамааралтай байгаа өнөө цагт бага хэмжээний хөрөнгийн эх үүсвэрийг оновчтой хуваарилах шаардлагатай байна.

4.40 Монгол Улсад төрийн үйл ажиллагаа, мэдээллийн ил тод байдал бүрэн хангагдаагүй, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй, ялангуяа бодлого тодорхойлж буй төрийн яамд, хөгжлийн төвүүд тухайн салбарын хүчин чадал, хөгжлийн чиг хандлага, салбарын нийт хүчин чадал, түүнд чиглэсэн судалгаа, шинжилгээний ажлыг үндэслэлтэй хийгээгүй, гарах үр дүн, үүсэж болох эрсдэлийг нийтэд ил тод мэдээлэхгүй, эдгээр мэдээллийг боловсруулах төрийн байгууллагуудын чадамж сул байгаагаас шалтгаалж зарим нь хохирох, эсвэл мэдээлэлд ойр байгаа нь давуу байдал олж авах явдал нийтлэг ажиглагдаж байна. Тухайлбал,

*Барилга, хот байгуулалтын яам*

- дотоодын барилгын материалын үйлдвэрлэлийн хэмжээ, үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний нэр төрөлд судалгаа, шинжилгээ хийсэн талаар баримт материал байхгүй;
- дотоодын барилгын аж ахуйн нэгжүүдийн хүний нөөц, техник хэрэгслийн хүчин чадлыг тодорхойлж, тэдгээрийн эдийн засагт нөлөөлөх нөлөөллийг тооцоогүй;

<sup>13</sup> 2018 онд хамгийн их буюу төгрөгийн төсөвт өртөг бүхий барилга байгууламж ашиглалтад орсон



- барилгын материалын үнийн өсөлтийг тооцох индексийг батлахын оронд үйлдвэрлэгч, борлуулагч нарын зах зээлийн дундаж үнийн судалгааг 2022 онд батлахдаа үнийг бодитой тооцоогүй;

Гадаад харилцааны яам

- гадаад худалдааны нэг цонхны бодлого байхгүйгээс экспортолж байгаа ижил төрлийн бараа бүтээгдэхүүн хооронд дотоодод үнээр өрсөлдөж байгаа нь нэгжийн үнийг бууруулж байна.

4.41 Иймд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу мэдээллийг ил тод, нээлттэйгээр оролцогч талуудыг тэгш хүртээмжтэй, үнэн, бодит мэдээллээр хангаж байх нь нэн шаардлагатай байна.

4.42 Эдийн засгийн үндсэн үзүүлэлтээс харахад ДНБ-ий үйлдвэрлэл 2020 онтой харьцуулахад 2021 онд 1.4 хувиар өсөхөд төсвийн зарлага 12.2 хувиар өссөн нь төсвөөр дамжуулан зарлагадсан мөнгөний өсөлт хийж, бүтээж, бий болгосон баялгийн өсөлтөөс 8.7 дахин их байгааг харуулж байна. Иймд төсвийг хуулийн дагуу төлөвлөдөг, төсөвлөдөг, зарцуулдаг тогтолцоо бүрдүүлэх, төрийн бүхий л түвшинд хуулийг сахин биелүүлж, хөрөнгө оруулалтын бодлогоо оновчтой тодорхойлж, урт хугацаанд тогтвортой хэрэгжүүлэх шаардлага хэвээр байна.

### Шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний хувьд:

4.43 Монгол Улсын Төсвийн тухай хуульд 2021 онд оруулсан нэмэлтээр 291 дүгээр зүйлийн 291.2.2-т “барилга байгууламжийн хувьд сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан зураг төсөл, төсөвтэй байх”, Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 7.2.2-т “барилга байгууламжийн хувьд сүүлийн 2 жилийн дотор хийгдсэн магадлалаар баталгаажсан зураг төсөл болон төсөвтэй байх” гэж заасны дагуу Монгол Улсын 2020-2022 оны төсвийн тухай хуулиар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээний жагсаалтад “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараа онуудад хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /улсын хэмжээнд/ төсөл, арга хэмжээг БХБС-ын багцад баталж ирсэн.

Хүснэгт 10 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараа онуудад хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах арга хэмжээний 2020-2021 оны гүйцэтгэл, сая төгрөг

Төсөл, арга хэмжээний нэр	Төсвийн тухай хуулийн огноо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Олгосон санхүүжилт	Ажлын гүйцэтгэл гараагүй санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан	Гүйцэтгэлийн хувь	Тайлбар
Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараа онуудад хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /улсын хэмжээнд/	2020 он	20,000.0	3,000.0	72.4		2.4	
	2021 он	37,900.0	31,900.0	28,201.5	3,698.5	88.4	2021 онд барьцаа хөрөнгийн дансанд 10,225.1 сая төгрөгийг байршуулж, 2022 онд 6,526.6 сая төгрөгийг санхүүжүүлсэн.
	2022 он	65,900.0	19,756.6	6,215.6		31.5	2022.09.30-ны өдрийн байдлаар
	2023 оны төсвийн төсөл	80,000.0	80,000.0				

Эх сурвалж: УАГ, Монгол Улсын 2023 оны төсвийн төсөл



4.44 Дээрх төсөл, арга хэмжээний 2020-2021 оны гүйцэтгэлээс харахад санхүүжилтийн ихэнх хэсгийг дараа онд төсөвт тусгах төсөл, арга хэмжээний зураг, төсөл, ТЭЗҮ-ийг боловсруулахад бус харин өмнө өр үүсгэсэн зургийн үнийг төлөх, хэний санаачилгаар болох нь тодорхойгүй хэрэгцээ шаардлагад үндэслээгүй зураг, төслийн үнийг төлөхөд зарцуулдаг байсан.

4.45 Монгол Улсын 2023 оны төсвийн төсөлд “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараа онуудад хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /улсын хэмжээнд/ боловсруулах төсөл, арга хэмжээнээс гадна 41,336.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 19,013.1 сая төгрөгөөр санхүүжих 15 төсөл, арга хэмжээг 3 Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

4.46 Монгол Улсын 2023 оны төсвийн төсөлд “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ, бэлтгэл хангалт /улсын хэмжээнд/” төсөл, арга хэмжээнд Сангийн сайдын багцад 80.0 тэрбум төгрөгийг төсөвлөсөн бөгөөд уг арга хэмжээний хүрээнд аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх эхлэлийг тавьж, барилгын зураг төсөл боловсруулах үйл ажиллагаа болон зураг төсвийг эхний ээлжинд санхүүжүүлэх зохицуулалтыг нэг цонхны бодлогоор хэрэгжүүлэхээр төлөвлөж, УИХ-ын тогтоолын төсөлд тусгасан нь тухайн хөрөнгө оруулалтын үр ашиг, хяналтыг сайжруулсан зохицуулалт гэж үзэж байна.

**Шилжих төсөл, арга хэмжээний хувьд:**

4.47 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд 7,089.4 тэрбум төгрөгийн өртөг бүхий 1376 төсөл, арга хэмжээг 1,697.4 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж, нийт төсөл, арга хэмжээнээс 751 буюу 54.9 хувь 2022 онд хэрэгжиж дуусах хугацаатай, 618 буюу 45.1 хувь нь 2023 онд үргэлжлэн хэрэгжихээр байна. Санхүүжилтийн гүйцэтгэл 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 887.4 тэрбум төгрөг буюу 52.3 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.

4.48 УИХ-ын 2021 оны “Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 88 дугаар тогтоолын 4-т “улсын төсвийн хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн төсөвт өртөгт нөлөөлж байгаа хүчин зүйлийг судалж, үнийн өөрчлөлтийн индексийг батлах”, 5-д “улсын төсвийн хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн төсөвт өртөгт магадлал хийх ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, холбогдох саналаа 2022 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө УИХ-д танилцуулах” гэж заасныг үндэслэн барилгын материалын үнийн өсөлт тооцсон магадлалаас 636 арга хэмжээнд 303.4 тэрбум төгрөгийн нэмэлт санхүүжилтийг олгохоор төсвийн төсөлд тусгасан байна.

Хүснэгт 11 Үнийн өсөлт тооцсон төсөл, арга хэмжээний тоо, төсөвт өртөг, санхүүжих дүн, сая төгрөг

Он	Төсөл, арга хэмжээний		Төсөвт өртөг		Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих жагсаалтад туссан	
	Тоо	Эзлэх хувь	Мөнгөн дүн	Эзлэх хувь	Мөнгөн дүн	Эзлэх хувь
2010	1	0.16	13,497.7	0.59	1,528.0	0.50
2011	2	0.31	14,492.0	0.64	717.2	0.24
2012	2	0.31	25,174.0	1.10	537.4	0.18
2013	2	0.31	7,356.4	0.32	1,466.6	0.48
2014	3	0.47	43,554.4	1.91	6,630.1	2.19
2015	3	0.47	31,493.7	1.38	1,443.5	0.48
2016	1	0.16	500.0	0.02	177.8	0.06
2018	37	5.82	158,865.7	6.97	15,741.5	5.19



2019	132	20.75	698,212.3	30.62	72,128.1	23.77
2020	250	39.31	869,483.4	38.13	135,448.9	44.64
2021	203	31.92	417,853.3	18.32	67,607.5	22.28
<b>Нийт</b>	<b>636</b>	<b>100.0</b>	<b>2,280,482.9</b>	<b>100.0</b>	<b>303,426.6</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Монгол Улсын 2023 оны төсвийн төсөл

4.49 Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5-д “Шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох хэсэг нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож тусгах” гэж заасныг хэрэгжүүлдэггүй, нэг жилд ногдох санхүүжилтийг хэрэгжих хугацаатай уялдуулж батлаагүй, олон төсөл, арга хэмжээг зэрэг эхлүүлдэг нь шилжих төсөл, арга хэмжээний тоо, төсөвт өртөг өсөх нөхцөлийг бүрдүүлж ирсэн. Жилээс жилд гаргадаг төлөвлөлтийн энэ оновчгүй байдал нь 2010-2019 онд хэрэгжсэн нийт 993.1 тэрбум төгрөгийн 183 төсөл, арга хэмжээ 2023 онд үнийн өсөлтөд өртөж, 100.4 тэрбум төгрөгийн нэмэлт санхүүжилт олгох үр дагаварт хүргэсэн байна.

4.50 Үнийн өсөлтийн тооцоололд нэг төрлийн материалын үнийг өөр өөрөөр илэрхийлсэн, үнийн индексээр тодорхойлсон өртөг нь зах зээлийн үнэтэй харьцуулахад харьцангуй өндөр байх зэрэг алдаа илэрч байна. Тухайлбал,

**Барилгын хөгжлийн төвийн хийсэн тооцоололд:**

- Нийтийн зориулалттай орон сууцны гадна фасадны ажлын материалын үнийн өсөлтөд галд тэсвэртэй хөөсөнцөр /150мм/ хавтангийн үнийг хэрхэн тооцсоныг түүвэрлэн авч үзэхэд БХБЯ-ны баталсан жишиг дээд үнэ, тооцоолол хийсэн үнэ зөрүүтэй байгаагаас хавсралт 2-т дурдсан нэр бүхий 6 төсөл, арга хэмжээний хувьд 178.2 сая төгрөгийн үнийн өсөлт илүү тооцсон байна. (Дэлгэрэнгүйг хавсралт 2-оос харна уу.)

**Эрчим хүчний хөгжлийн төвийн хийсэн тооцоололд:**

- БХБЯ-аас бараа материалын үйлдвэрлэгч, борлуулагч нарын зах зээлийн дундаж үнийг харилцан адилгүй зөрүүтэй баталгаажуулснаас бараа материалын үнийн өсөлтийг харилцан адилгүй тооцох эрсдэл үүссэн байна. Мөн шахмал түлшний үйлдвэрт зориулж бараа материалын үнийн жагсаалт баталсан нь бусдад давуу байдал олгосон байх магадлалтай байна. (Дэлгэрэнгүйг хавсралт 3-аас харна уу.)

4.51 Үндэсний аудитын газраас 2022 онд “Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн аудитаар барилга, угсралтын ажил гүйцэтгэхдээ материалын чанар байдал доройтуулж, материал сольж ажил гүйцэтгэсэн 7 төсөл, арга хэмжээнд 413.1 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосон. Эдгээр арга хэмжээний хувьд үнийн өсөлтийг хэрхэн тооцсоныг түүвэрлэн авч үзвэл дараах байдалтай байна. Тухайлбал,

- Сангийн сайдын багцад хуулийн VI.3.1.1 дугаартай 16,111.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Татварын хэлтсийн барилга /Улаанбаатар, Хөвсгөл, Увс, Баянхонгор/ төсөл, арга хэмжээнд 2,689.2 сая төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөсөн бөгөөд Татварын хэлтсийн барилга /Хөвсгөл аймаг, Мөрөн сум/ барилгын гадна заслын ажлыг 764.23 м.кв дулаалгатай гантиган хавтангаар өнгөлөхөөр ажлын зураг, төсөвт тусгаж магадлалаар баталгаажсан байхад металл хавтангаар хийсэн бөгөөд үнийн өсөлтийг гантиган хавтангаар тооцсоноос 75.7 сая төгрөгийн хасах зөрүү үүссэн;
- БШУС-ын багцад хуулийн XI.1.1.169 дугаартай Сургуулийн барилгын өргөтгөл /Хэнтий, Баян-Адрага сум/ 1,881.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч батлагдсан зураг төсөл, төсөв дэх гадна заслын ажил 360мм-ийн тоосго, 150мм-ийн хөөсөнцөр дулаалга, 120 мм-ийн өнгөлгөөний тоосгон өрлөгийг 150мм-ийн хөөсөнцөр дулаалга, шавардлага чулуун гоёл болгон өөрчилсөн бөгөөд үнийн өсөлтийг тооцохдоо төсөвт туссан материалаар тооцсоноос 21.6 сая төгрөгийн хасагдах зөрүү үүссэн;
- Соёлын сайдын багцад хуулийн XI.1.25 дугаартай 3,783.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Орон нутаг судлах музейн барилга /Хэнтий, Хэрлэн сум/ төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч тус барилгын 1305.4 м.кв дотор шалны ажлыг шахмал чулуу дэвсэж хийхээр байсныг плитагаар сольж хийсэн, үнийн өсөлтийг чулуугаар тооцсоноос 140.3 сая төгрөгийн хасагдах зөрүү үүссэн тул дээрх 3 төсөл, арга хэмжээний санхүүжилтээс 237.6 сая төгрөгөөр бууруулахаар байна.



4.52 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлд хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулахад баримтлах журмыг тодорхойлсон. Иймд Төрийн хэмнэлтийн тухай хууль болон төсөл, арга хэмжээний хэрэгжилттэй уялдуулан ЭМС-ын багцад хуулийн XV.1.16 дугаараар тусгасан “Сүрьеэгийн эмнэлгийн барилга, УБ” төсөл, арга хэмжээг хасах саналтай байна. Уг эмнэлгийн барилгын ажлыг 2019 оноос эхлэн 2024 онд хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөсөн бөгөөд төсөвт өртөг 18,500.0 сая төгрөг, 2023 онд санхүүжих дүнг 2,000.0 сая төгрөг байхаар хуулийн төсөлд тусгасан байна. Эмнэлгийн барилгын худалдан авах ажиллагааны үр дүн гараагүй, мөн Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэр шинэ суурьшлын бүсэд баригдах “Халдварт өвчин судлалын үндэсний төв-II цогц арга хэмжээний хүрээнд давхар төлөвлөгдсөн тул эдийн засгийн хувьд үр ашиггүй, давхардсан төлөвлөлт болсон байна.

## **ТАВ. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА**

5.1 Төрийн аудитын байгууллага Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу өмнөх аудитын тайланд дурдсан асуудал, зөвлөмжийн мөрөөр хариуцагч талын авч хэрэгжүүлсэн арга хэмжээний гүйцэтгэлд хяналт үнэлгээ хийх үүрэгтэй.

5.2 Энэ нь өмнөх аудитын үр нөлөөг батжуулж, дараагийн аудитын чанар, үр нөлөөг сайжруулах нөхцөл болох бөгөөд аудитын үнэ цэнийг нэмэгдүүлэх, зорилтот хэрэглэгчийг өмнө хийсэн аудитын тайлан болон тухайн үеийн нөхцөл байдлыг эргэн санах, дүгнэх боломж олгодог чухал ач холбогдолтой аудитын нэг үе шат юм.

5.3 Монгол Улсын Их Хурал “Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 2021 оны 88 дугаар тогтоолоор Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн төсөлд дүгнэлт гаргасан аудитын тайланд тусгагдсан асуудал, өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах ажлыг төрийн аудитын байгууллагад даалгасан.

5.4 Аудитын баг эдгээр шаардлагын дагуу Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн төсөлд дүгнэлт гаргах аудитын тайланд дурдсан асуудал, өгсөн зөвлөмжийн мөрөөр авсан арга хэмжээний гүйцэтгэл, үр дүнгийн талаарх мэдээлэл цуглуулан дүн шинжилгээ хийж, зөвлөмжийн биелэлтийг хавсралт 6-д үзүүлэв.

5.5 Төрийн аудитын байгууллага өмнөх аудитаар өгсөн төсвийн хүрээний мэдэгдлийг өөрчлөхгүй байх буюу хүчин төгөлдөр үйлчилж буй төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн жилийн төсвийн төслийг боловсруулах, Төсвийн төлөвлөлттэй холбоотой программ хангамжуудыг хөгжүүлэх, уялдааг хангах замаар төсвийг төлөвлөх, шат шатанд өргөн мэдүүлэх, нэгтгэх, дүн шинжилгээ хийх үйл явцыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг төлөвлөн хэрэгжүүлж, үр дүнг тайлагнах зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

5.6 Төрийн аудитын байгууллага өмнөх аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар дараагийн шатны арга хэмжээ болох албан шаардлагыг Монгол Улсын Засгийн газарт хүргүүлэв.





## ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс болон аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт гаргаж байна.

1. Монгол Улсын 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөлөлд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 18,921.9 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 34.7 хувь, нийт зарлага 20,475.3 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 37.6 хувь, тэнцвэржүүлсэн тэнцэл 1,553.4 тэрбум төгрөг буюу ДНБ-ий -2.8 хувьтай тэнцэж байгаа нь төсвийн тусгай шаардлагыг хангаж байна.

2. Төсвийн төсөлд “Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгасан тодорхой зорилт, үйл ажиллагаанд санхүүжилт тусгасан хэдий ч төсвийн ерөнхийлөн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг хөгжлийн бодлогын баримт бичигт нийцүүлээгүй, үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцсэн эсэхийг үнэлэх боломж хязгаарлагдмал байна.

3. Төсвийн ерөнхийлөн захирагч нар тогтвортой хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан зорилтыг хангахад чиглэсэн салбарын бодлогын тэргүүлэх чиглэлийг санхүүжүүлэх хэрэгцээг үнэлж, төсвийн төлөвлөлтийг дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдуулахгүй байна.

4. Төсвийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн УИХ-ын тогтоолын 2.7-д өөрчлөлт оруулах замаар орлогыг 192.4 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.

5. Төсвийн төсөлд халамжийн зардлыг өмнөх онуудаас бууруулахгүй төсөвлөж байгаагаас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого хэрэгжих нөхцөл бүрдэхгүй байна.

6. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар өмнөх оноос шилжин хэрэгжиж буй төсөл, арга хэмжээг дуусгах чиглэлийг баримталсан нь хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, эдийн засгийн өсөлтийг дэмжих эхлэлийг тавьсан арга хэмжээ болсон байна. Гэвч улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр баригдаж эхлээд дуусаагүй орхигдсон, үнийн өсөлт тооцуулж 2023 оны төсвийн төсөлд тусгаагүй, 2022 онд хэрэгжиж дуусах хугацаатай ч ажлын гүйцэтгэл нь бүрэн хангагдаагүй арга хэмжээ дараа жилүүдэд үргэлжлэхээр байна.

7. Төсвийн төсөлд тусгасан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлтийг Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлэх, сонгох, эрэмбэлэх үйл ажиллагааны журам болон аргачлалууд”-ын дагуу 16 шалгуур үзүүлэлтээр цахим системд төлөвлөн, эдийн засгийн болон нийгмийн ач холбогдлоор нь эрэмбэлж төлөвлөсөн байна.

8. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, “Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-т 2023 онд улсын төсвөөр хэрэгжүүлэх нийт 20 төсөл, хөтөлбөрт 754.5 тэрбум төгрөг төсөвлөхөөс 12 төсөл, хөтөлбөрийн 356.8 тэрбум төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг төсвийн төсөлд тусгаагүй байна. Иймд эдийн засгийн хүндрэлтэй нөхцөлд төсөл, хөтөлбөрийн хэрэгцээ шаардлагатай уялдуулан дээрх хөтөлбөрт өөрчлөлт оруулах нь зүйтэй байна.

9. Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулах чиглэлээр төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангаагүй, судалгаа, туршилт тохируулга хийгээгүй, цахилгаан автобусны хэрэглээ, цэнэглэлт, цэнэглэх цэгүүдийн байршлыг оновчтой тодорхойлох, газар чөлөөлөх зэрэг нь тодорхойгүй байгаагаас хэрэгжилтэд эрсдэл үүсэхээр байна.



10. Улсын төсвийн санхүүжилтээр бэлтгэсэн зураг, төсөл, техник, эдийн засгийн үндэслэлийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлээгүйгээс хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хяналт хэрэгжүүлэх боломжгүй байгаа тул нэгдсэн хяналтыг бий болгох шаардлагатай байна.

11. Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг барилга, угсралтын ажлыг гүйцэтгэх салбарын чадамж, дотоодын барилгын материалын үйлдвэрлэлийн хүчин чадалтай уялдуулаагүй, нэг дор хэт олон арга хэмжээг зэрэг хэрэгжүүлж байгаа нь төсөвт өртөг нэмэгдэх сөрөг үр дагаварыг бий болгож байна.

12. Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн төсөлд дүгнэлт гаргах аудитаар өгсөн зарим зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, зөрчил дутагдал давтагдсан хэвээр байгаа бөгөөд нааштай үр дүн гараагүй байгаа нь өмнөх дүгнэлтийн ач холбогдол, үр нөлөөг бууруулж, төсвийн сахилга хариуцлага шат шатандаа алдагдаж байгааг харуулж байна.



## **ЗӨВЛӨМЖ:**

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

### **Монгол Улсын Их Хурлын анхааралд толилуулах нь:**

1. Төсвийн төсөл үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцсэн эсэхийг хэрхэн үнэлж, дүгнэх эрх зүйн зохицуулалт, аргачлал, шалгуур үзүүлэлтийг холбогдох хууль тогтоомж, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нэмэлтээр тусгах;
2. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, 3.1.4-т зааснаас бусад этгээд үйл ажиллагааны санхүүгийн сахилга бат, хэмнэлтийн талаар хэрхэн тайлагнах, ил тод мэдээлэх, хууль зөрчигчид хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг бий болгох;
3. Улсын Их Хурлаас батлах “Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” тогтоолд уул уурхай болон бусад салбарын төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдээс төвлөрүүлэх ногдол ашгийн хэмжээг нэмэгдүүлэх заалтыг тусгах;

### **Монгол Улсын Засгийн газарт:**

4. Төсвийн ерөнхийлөн захирагч нар тогтвортой хөгжлийн зорилтод чиглэсэн хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэлийг санхүүжүүлэх хэрэгцээг үнэлж, санхүүгийн хэрэгцээний талаарх мэдээллийг зорилт тус бүрээр тооцдог болох;
5. Төсвийн ерөнхийлөн захирагч нар тогтвортой хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан зорилтыг хангахад чиглэсэн салбарын бодлогын тэргүүлэх чиглэлийг санхүүжүүлэх хэрэгцээг үнэлж, төсвийн төлөвлөлт, хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнг дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт уялдуулах;
6. Улсын төсөв боловсруулахдаа үндэсний аюулгүй байдлын бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллагуудын санал, зөвлөмжийг авч тусгах;
7. Материалын үнийн өсөлтийн санхүүжилтийг олгохдоо үнийн өсөлт тооцсон материалын нэг бүрийн үнэ, бодит ажлын гүйцэтгэлийн тоо, хэмжээ, ашигласан материалд үндэслэн дахин тооцоолол хийж олгох;
8. Төсвийн хөрөнгөөр боловсруулсан барилга, байгууламжийн зураг төсөл, техник эдийн засгийн үндэслэлийн мэдээллийн нэгдсэн цахим сан бүрдүүлж, төсвийн төлөвлөлтөд ил тод, нээлттэй ашиглах боломж бүрдүүлэх;
9. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, шаардлагыг хэрэгжүүлэх ажлыг шат шатанд зохион байгуулж, биелэлтийн талаарх мэдээллийг 2022 онд багтааж Үндэсний аудитын газарт ирүүлэх.



## ХАВСРАЛТУУД:

### Хавсралт 1

Хүснэгт 12 Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнгийн чанарын болон тоо хэмжээний Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд нийцсэн байдал:

№	Төсвийн ерөнхийлөн захирагч	Тусгагдсан	Агуулгын хувьд тусгагдсан, хүрэх үр дүн зөрүүтэй	Нийт
1	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	1	4	5
2	Барилга, хот байгуулалтын сайд	-	1	1
3	Боловсрол, шинжлэх ухааны сайд	3	3	6
4	Санхүүгийн зохицуулах хорооны дарга	-	1	1
5	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	-	2	2
6	Хууль зүй, дотоод хэргийн сайд	-	3	3
7	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	1	4	5
8	Цахим хөгжил, харилцаа холбооны сайд	-	1	1
<b>Нийт дүн</b>		<b>5</b>	<b>19</b>	<b>24</b>

Хүснэгт 13 Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнгийн чанарын болон тоо хэмжээний Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн шалгуур үзүүлэлтэд нийцсэн байдал:

№	Төсвийн ерөнхийлөн захирагч	Тусгагдсан	Агуулгын хувьд тусгагдсан, хүрэх үр дүн зөрүүтэй	Нийт
1	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	1	2	3
2	Боловсрол, шинжлэх ухааны сайд	4	1	5
3	Зам, тээврийн хөгжлийн сайд	3	-	3
4	Монгол Улсын шадар сайд	1	-	1
5	Монгол Улсын шадар сайд бөгөөд эдийн засаг, хөгжлийн сайд	1	-	1
6	Соёлын сайд	-	3	3
7	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	-	1	1
8	Эрүүл мэндийн сайд	8	-	8
<b>Нийт дүн</b>		<b>18</b>	<b>7</b>	<b>25</b>

Хүснэгт 14 Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнгийн чанарын болон тоо хэмжээний Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтэд нийцсэн байдал:

№	Төсвийн ерөнхийлөн захирагч	Тусгагдсан	Агуулгын хувьд тусгагдсан, хүрэх үр дүн зөрүүтэй	Нийт
1	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	-	4	4
2	Боловсрол, шинжлэх ухааны сайд	3	-	3
3	Гадаад харилцааны сайд	1	1	2
4	Зам, тээврийн хөгжлийн сайд	-	2	2
5	Монгол Улсын Ерөнхий сайд	1	-	1



6	Монгол Улсын сайд, нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах үндэсний хорооны дарга	-	1	1
7	Монгол Улсын шадар сайд бөгөөд эдийн засаг, хөгжлийн сайд	1	-	1
8	Соёлын сайд	-	2	2
9	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд	-	3	3
10	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	2	-	2
11	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	2	3	5
12	Цахим хөгжил, харилцаа холбооны сайд	2	-	2
13	Эрүүл мэндийн сайд	4	4	8
<b>Нийт дүн</b>		<b>16</b>	<b>20</b>	<b>36</b>

## Хавсралт 2

Хүснэгт 15 "Шинэ сэргэлтийн бодлого"-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөгжлийн төслийн улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад тусгасан байдал

№	"Шинэ сэргэлтийн бодлого"-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөгжлийн төсөл	"Монгол улсын төсвийн хөрөнгөөр 2023 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн нэр	Санхүүжих дүн /сая төгрөг/
1	Эрчим хүчний дэд станц, цахилгаан дамжуулах агаарын шугам сүлжээний төслүүд	Хөшөөтийн уурхайгаас Ховд аймгийн Үенч сум хүртэл 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, Үенч дэд станцын өргөтгөл /Ховд, Үенч сум/	3,038.3
2		Тайширын усан цахилгаан станцаас аймгийн төв рүү татах 110 кВ-ын ЦДАШ, дэд станц /Говь-Алтай/	3,545.7
3		Гэр хорооллын хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр хангах шугам, дэд станц /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 4, 5, 8, 13, 16 дугаар хороо/	178.1
4		"Монголын нууц товчоо" цогцолборын барилгын гадна цахилгаан хангамжид 10 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, 10/04 кВ-н хүчдэлтэй 250 КВа-н чадалтай дэд станц /Хэнтий, Дэлгэрхаан сум/	345.1
5		Сум, суурин газрын цахилгаан хангамж, шугам сүлжээ, дэд станц /Улсын хэмжээнд/	3,992.3
6	Аж үйлдвэрлэл, технологийн парк цогцолборуудыг барих төслүүд	Үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтэц /Сүхбаатар/	939.8
7	Хөдөө аж ахуй, газар тариалан, хүнсний дотоодын хангамжийг сайжруулах төслүүд	Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн кластер байгуулах /Баянхонгор/	3,962.8
8		Цэцгийн тос үйлдвэрлэх сүүний ферм /Булган, Тэшиг сум/	2,680.0
9		Хүлэмжийн аж ахуй /Хөвсгөл, Мөрөн сум/	200.0
10	Нийслэл Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулах төслүүд	Нийтийн тээврийн автопарк /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	21,743.2
11		Нийтийн тээврийн автобус /Улаанбаатар/	318,000.0
12	Төвлөрлийг сааруулах, шинэ суурьшлын бүс, хот байгуулах дэд бүтэц болон барилга байгууламжийн төслүүд	Аймгийн шинэ суурьшлын бүсийн инженерийн шугам сүлжээ /Баянхонгор, Баянхонгор сум/	6,481.1
13		Аймгуудын шинэ суурьшлын бүсэд баригдах орон сууцны хорооллын шугам сүлжээ, дэд бүтэц /Улсын хэмжээнд/	23,340.2



14		Аймгийн шинэ суурьшлын бүсийн хатуу хучилттай авто зам, 10 км /Баянхонгор, Баянхонгор сум/	6,195.2
15		Шинэ суурьшлын бүсийн хэрэглэгчдийг эрчим хүчинд холбох /Хэнтий, Баянхутаг, Батширээт, Дадал, Норовлин, Өмнөдэлгээр, Хэрлэн сум/	509.5
17		Шинэ суурьшлын бүсийн цахилгаан хангамж, цахилгааны хуваарилах байгууламж - РП /Улаанбаатар, Багануур дүүрэг, 1, 3, 4 дүгээр хороо/	995.3
18	Усны нөөцийг хуримтлуулж, говийн бүсийн ус хангамжийн хүртээмжийг нэмэгдүүлэх төслүүд	Гурван нуурын усны нөөцийг нэмэгдүүлэх зураг төсөв /Хэнтий, Дадал сум/	240.0
19		Цэвэр усны нөөц сан /Дорноговь/	283.5
20	Иргэн, хувийн хэвшил, хөрөнгө оруулагчдад ээлтэй төрийн оновчтой бүтцийг тодорхойлох, төрийн үйлчилгээг цахимжуулах төслүүд	Санхүүгийн зохицуулах хорооны цахим хяналт шалгалтын тоног төхөөрөмж /Улаанбаатар/	458.0



**Хавсралт 3**

**Хүснэгт 16 Төсвийн хүрээний мэдээгдлийн/ТХМ/ 2018-2021 оны үзүүлэлтүүд ба бодит гүйцэтгэлийг 2023 оны ТХМ-ийн болон шинээр өргөн мэдүүлсэн ТХМ-ийн үзүүлэлтийн харьцуулалт**

Он ("Тооцсон" гэдэг нь тухайн оны Төсвийн хүрээний мэдээгдэлд туссан дүнг илэрхийлнэ)	2018		2019		2020		2021		2022	Хүчин төгөлдөр 2022.05.27	Шинэ санал 2022.09.29	Өөрчлөлт
	Тооцсон	Бодит	Тооцсон	Бодит	Тооцсон	Бодит	Тооцсон	Бодит	Тооцсон	2023*	2023	4 сард
ДНБ (2015 оны зэрэгцүүлэх үнээр, тэрбум₮)	n/a	26,446.7	27,622.7	27,928.3	28,276.8	26,655.4	29,446.2	27,034.2	27,737.04	29,123.9	<b>29,123.9</b>	-
ДНБ-ий бодит өсөлт /тэрбум₮/	n/a	1,901.03	2,046.12	1,481.61	(285.62)	(1,272.90)	1,797.18	378.78	702.89	1,386.9	<b>1,386.9</b>	-
ДНБ-ий бодит өсөлт /хувиар/	4.2%	<b>7.7%</b>	8.0%	<b>5.6%</b>	-1.0%	<b>-4.6%</b>	6.5%	<b>1.4%</b>	<b>2.6%</b>	5.0%	<b>5.0%</b>	0.0%
ДНБ (оны үнээр, тэрбум₮)	30,251.3	32,582.6	35,431.5	37,839.2	38,772.8	37,453.3	41,952.3	43,018.6	46,805.5	52,757.6	<b>54,514.6</b>	1,756.96
ДНБ-ий өсөлт (оны үнээр, тэрбум₮)	2,813.25	4,571.92	5,180.23	5,256.60	3,341.32	(385.95)	3,179.47	5,565.35	3,786.85	5,952.17	<b>7,709.13</b>	1,756.96
Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ /хувь/	4.2%	<b>7.7%</b>	8.0%	<b>5.6%</b>	-1.0%	<b>-4.6%</b>	6.5%	<b>1.4%</b>	<b>2.6%</b>	5.0%	<b>5.0%</b>	0.0%
Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин	8.6	8.1	8	5.2	3.8	2.3	7.2	13.4	11.5	8%	<b>8%</b>	0.0%
Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/	7,231.4	9,225.9	9,676.5	10,905.5	9,730.9	9,463.8	12,056.4	12,689.4	15,526.4	17,312.2	<b>18,921.9</b>	1,609.70
-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	23.8%	28.3%	27.4%	28.8%	25.2%	25.3%	28.6%	29.5%	33.3%	32.7%	<b>34.7%</b>	
Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	9,651.5	9,317.2	11,589.8	11,661.7	14,577.5	13,904.3	15,748.3	15,630.4	17,913.5	19,219.10	<b>20,475.30</b>	1,256.20
-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	31.8%	28.6%	32.8%	30.8%	37.7%	37.1%	37.4%	36.3%	38.4%	36.3%	<b>37.6%</b>	
Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ /тэрбум төгрөг/	497.0	299.88	1,938.2	2,344.5	704.9	2,242.6	1,844.0	1,726.1	2,165.2	1,305.6	<b>2,561.8</b>	1,256.21
-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	1.6%	0.9%	5.5%	6.2%	1.8%	6.0%	4.4%	4.0%	4.6%	2.5%	<b>4.7%</b>	
Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	(2,420.1)	3.0	(1,913.3)	(756.2)	(4,846.6)	(4,440.4)	(3,691.8)	(2,919.0)	-2387.1	(1,906.8)	<b>(1,553.4)</b>	(353.40)
-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	-8.0%	0.01%	-5.4%	-2.0%	-12.5%	-11.9%	-8.8%	-6.8%	-5.1%	-3.6%	<b>-2.8%</b>	
Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тэрбум төгрөг/	1,928.5	1,607.8	3,251.8	3,016.7	3,408.0	3,034.2	3,363.5	2,982.2	4,296.3	4,484.4	<b>5,347.3</b>	862.91
-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	6.3%	4.9%	9.2%	8.0%	8.8%	8.1%	8.0%	6.9%	9.2%	8.5%	<b>9.8%</b>	



Засгийн газрын өрийн нийт хэмжээ, өнөөгийн үнэ цэнээр /тэрбум төгрөг/	24,309.6	18,955.9	19,551.6	20,525.6	24,065.8	23,024.30	25818.4	21,837.30	28,261.7	34,428.4	35,434.5	1,006.10
-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	80.0%	58.2%	55.3%	54.2%	62.2%	61.5%	61.3%	50.8%	60.7%	65.0%	65.0%	
Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/	646.0	n/a	694.5	n/a	1,650.2	n/a	2,994.7	n/a	490.4	604.8	1,999.0	1,394.20
-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	2.1%	n/a	2.0%	n/a	4.3%	n/a	7.1%	n/a	1.1%	1.1%	3.7%	





**Хавсралт 4**

Хүснэгт 17 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаад дуусаагүй, орхигдсон барилга, байгууламжийн судалгаа

№	Барилга байгууламжийн нэр	Байршил	Захиалагч ТЭЗ	Төсөвт өртөг	Гэрээний үнийн дүн	Эхэлсэн хугацаа	Дуусгах хугацаа	Нийт олгосон санхүүжилт
1	Хог боловсруулах үйлдвэрийн барилга	УБ, БЗД, 24 дүгээр хороо	БОАЖС	10,000.0	9,793.2	2012	2014	5,721.6
2	Улз голын урсцыг нэмэгдүүлэх "Онон-Улз" төсөл /Дорнод, Хэрлэн сум/	Дорнод, Баяндун сум	БОАЖС	2,500.0	2,392.7	2019	2021	902.4
3	Үйлчилгээний төвийн барилга	Сэлэнгэ, Ерөө сум	БХБС	250.0	249.6	2012	2015	242.0
4	Яармагийн гүүр орчмын ОСХ-ын дэд станцаас 10 КВ-ын 3 иж бүрдэл ХБ руу татах 12 км, 15 МВТ чадлын хэрэглээг хангах кабель шугамын зураг төсөл, барилга, угсралтын ажил	УБ, ХУД	БХБС	968.7	968.7	2013	2017	968.7
5	Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламжийн өргөтгөл төслийн монголын талын хөрөнгө /Францын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр/	Орхон, Баян-Өндөр сум	БХБС	9,322.1	9,224.8	2013	2017	9,322.1
6	Сумын төвийн шинэчлэл төсөл	Говь-Алтай, Дэлгэр	БХБС	5,000.0	5,000.0	2013	2018	4,529.9
7	Соёлын төвийн барилга /Сумын төвийн шинэчлэл хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж эхэлсэн/	Дорноговь, Замын-Үүд сум	БХБС	5,844.1	5,844.1	2013	2016	2,680.8
8	Ирээдүй цогцолбор хорооллын 2 дугаар ээлжийн бохир усны Ф 150-450 мм-ийн голчтой 2200 м гол шугамын зураг төсөл, барилга, угсралтын ажил	УБ, ХУД	БХБС	388.8	388.8	2014	2016	382.2
9	14 дүгээр хорооллын бохир усны ф200/300мм-ийн 1128 метр, ф300 мм-ийн 1185 метр шугамын зураг төсөв, барилга угсралтын ажил, Цэвэр усны ф150-250 мм-ийн 2103 метр, ф125/200 мм-ийн 1065 метр шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил	УБ, БЗД	БХБС	1,596.0	778.7	2014	2015	387.8
10	14 дүгээр хорооллын цахилгааны 110/35/10кв-ын дэд станцын гаргалгаа-4ком, 10кв-ын хаалттай хуваарилах байгууламж-3ком, 10кв-ын хаалттай дэд өртөө -12 ком, 10кв-ын 18.4км кабель шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил.	УБ, БЗД	БХБС	7,137.0	7,137.0	2014	2015	4,006.1
11	Цэвэр усны Ф32/150 мм-ийн 1400 метр шугамын барилга угсралтын ажил	УБ, ЧД 13,15 дугаар хороо	БХБС	182.0	182.0	2014	2015	142.4
12	Хайлааст орчмын дулааны хангамжийн эх үүсвэр, хатуу түлшний халаалтын тогоо-5ш, ялтсан дулаан солилцуур-3 ком-ын барилга угсралтын ажил	УБ, ЧД 13,15 дугаар хороо	БХБС	933.8	933.8	2014	2015	653.7
13	Хайлааст орчмын дулааны шугам сүлжээний ф32/200мм-ийн голчтой 3539 метрийн шугамын барилга угсралтын ажил	УБ, ЧД 13,15 дугаар хороо	БХБС	942.3	942.3	2014	2015	632.5
14	Дулааны ф65/200мм-ийн 924 метр шугамын зураг төсөв, барилга угсралтын ажил	УБ, СХД 10 дугаар хороо	БХБС	754.0	754.0	2014	2015	226.2
15	Усан хангамж ф32/150мм 871 метр шугам, ариутгах татуургын ф150/300мм-ийн голчтой 3100 метр шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил	УБ, СХД 10 дугаар хороо	БХБС	858.0	858.0	2014	2015	270.3



16	14 дүгээр хорооллын ус дулаан дамжуулах төв 4 ш, ф200/300мм-ийн 1134 метр, ф125/250мм 2239 метр шугамын зураг төсөв, барилга угсралтын ажил	УБ, БЗД	БХБС	5,369.0	3,480.3	2014	2015	1,881.6
17	Яармаг ОСХ-ын цахилгаан хангамжид зориулан 10 кв түгээх сүлжээнд 14.3 МВт чадлын хэрэглээг хангах 10 кв-ын ХБ 3 иж бүрдэл, 2*400 кВА чадалтай ТП 36 иж бүрдэл 37.6 км урт 10 кв-ын кабель шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил	УБ, ХУД	БХБС	8,746.1	8,746.1	2015	2017	8,536.2
18	МҮОНРТ орчмын хорооллын 6 хэсгийн 6 ширхэг ус, дулаан дамжуулах төвийн барилга, гадна цахилгаан хангамжийн зураг төсөл, барилга угсралтын ажлын нэмэлт ажил	УБ, ЧД	БХБС	1,633.0	571.0	2017	2017	328.5
19	Халуун ус, ахуй үйлчилгээний барилга	Дундговь, Цагаандэлгэр сум	БХБС	250.0	237.3	2018	2018	178.3
20	Баянцагаан багийн инженерийн шугам сүлжээ	Орхон, Баян-Өндөр сум, Баянцагаан баг	БХБС	3,400.0	3,400.0	2018	2021	98.9
21	Баянгол дүүргийн орон сууцны байруудын дулаалга	УБ, БГД 8,12, 13 дугаар хороо	БХБС	996.6	928.2	2019	2019	912.2
22	Соёлын төвийн барилга	Баянхонгор, Бууцагаан сум	БШУС	664.7	869.7	2008	2012	252.6
23	Бага сургуулийн барилга	Баянхонгор, Бууцагаан сум	БШУС	500.0	939.5	2012	2012	475.0
24	Цэцэрлэгийн барилга	Сэлэнгэ, Мандал сум	БШУС	771.2	762.9	2014	2015	478.2
25	Цэцэрлэгийн барилга	УБ, ХУД, 14 дүгээр хороо	БШУС	1,849.1	1,750.0	2018	2019	849.1
26	Цэцэрлэгийн барилга	Говь-Алтай, Халиун сум	БШУС	787.1	787.1	2018	2019	500.0
27	Цэцэрлэгийн барилга	Сүхбаатар, Эрдэнэцагаан сум	БШУС	2,160.0	1,844.6	2018	2019	285.4
28	Сургуулийн барилга	Орхон, Баян-Өндөр сум, Рашаант баг	БШУС	2,496.4	2,496.4	2019	2019	2,496.4
29	Цэцэрлэгийн барилга	Сүхбаатар, Баяндэлгэр сум	БШУС	2,100.0	1,980.0	2019	2020	564.7
30	Соёлын төвийн барилга	Орхон, Баян-Өндөр сум, Наран баг	БШУС	1,000.0	1,000.0	2019	2020	806.4
31	Цэцэрлэгийн барилгын их засвар	Сэлэнгэ, Мандал сум, Хэрх тосгон	БШУС	257.3	236.2	2020	2020	188.7
32	Спорт, сургалтын цогцолборын барилгын их засвар	Сэлэнгэ, Мандал сум	БШУС	200.0	180.3	2020	2020	90.2
33	Цэцэрлэгийн барилгын их засвар	Сэлэнгэ, Мандал сум, 1 дүгээр цэцэрлэг/	БШУС	199.3	179.3	2020	2020	88.0
34	Сургуулийн барилга	Орхон, Баян-Өндөр сум, Говил баг	БШУС	2,000.0	2,000.0	2020	2021	2,000.0



35	Төрийн үйлчилгээний цогцолборын барилга	УБ, СБД, 6 дугаар хороо	ЗГХЭГ	1,080.0	928.9	2018	2020	580.0
36	Төв халхын дуулалт жүжгийн театрын барилга	Дундговь, Сайнцагаан сум	СоС	6,800.0	6,800.0	2012	2014	2,040.0
37	Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийн агуулах	УБ, СХД, Рашаант өртөө	УУХҮС	21,900.0	21,900.0	2012	2014	3,583.9
38	Ахмадын сувилалыг өргөжүүлж өвлийн барилга барих	УБ, СБД, 19 дүгээр хороо	ХНХС	500.0	488.0	2011	2011	437.4
39	Ахмадын сувилалын газрын барилга	УБ, СБД, 19 дүгээр хороо	ХНХС	287.7	287.7	2015	2015	287.7
40	Ахмадын өргөөний барилга	УБ, БЗД, 11, 12 дугаар хороо	ХНХС	400.0	398.5	2018	2019	398.5
41	Боршоо олон улсын худалдааны төвийн барилга	Увс, Давст сум	ХХААХҮ С	400.0	389.2	2011	2012	271.6
42	Малын гаралтай түүхий эдийн цэвэрлэх байгууламж	Ховд, Жаргалант сум	ХХААХҮ С	5,000.0	4,789.9	2018	2020	3,670.0
43	Шүүхийн цогцолбор барилга	УБ, ХУД, 21 дүгээр хороо, Буянт-Ухаа-2 орон сууцны хорооллын чанх хойно	ШЕЗ	40,635.2	40,615.6	2013	2015	4,964.3
44	Эрүүл мэндийн төвийн барилга	Дундговь, Дэлгэрхангай сум	ЭМС	200.0	200.0	2011	2011	200.0
45	Спорт цогцолборын өргөтгөл, усан бассейн	Дорнод, Хэрлэн сум	ЭМС	1,770.3	1,770.3	2011	2015	384.0
46	Төрөх эмнэлэг, 50 ортой	Дорноговь, Сайншанд сум	ЭМС	1,285.7	1,285.7	2011	2012	1,285.7
47	Геронтологийн төв, ахмадын 60 ортой эмнэлгийн барилга	УБ, ХУД, 10 дугаар хороо	ЭМС	4,724.6	2,995.2	2011	2012	6,214.6
48	Эрүүл мэндийн төвийн барилга	Баян-Өлгий, Өлгий сум, 7 дугаар Хотгор баг	ЭМС	250.0	245.0	2019	2019	245.0
49	Шинэ суурьшлын бүсийн цахилгаан дамжуулах агаарын шугам, 250кВт АТП	Сэлэнгэ, Мандал сум	ЭХС	4,000.0	2,999.9	2018	2018	2,294.6
50	Усан хангамжийн Ф50-150м-ийн 580 метр шугамын барилга угсралтын ажил	УБ, СХД, 10 дугаар хороо	НЗДБУБ ХЗ УТХО	91.2	91.2	2014	2015	27.0
51	Дулааны Ф65-200мм 1714 метр шугамын барилга угсралтын ажил	УБ, СХД, 10 дугаар хороо	НЗДБУБ ХЗ УТХО	1,878.7	1,878.7	2014	2015	741.0
52	Дулаан хангамжийн эх үүсвэр зураг төсөл, барилга угсралтын ажил	УБ, СХД, 10 дугаар хороо	НЗДБУБ ХЗ УТХО	3,471.0	3,470.9	2014	2015	1,206.0
53	Монлааны Чандмань булаг булгийн орчмыг тохижуулах /3-н ундаргатай, Тахилтын ам Бөөрний булаг тохижуулах/	УБ, СХД, 7, 22 дугаар хороо	НЗДБУБ ХЗ НОНХС	28.0	27.9	2014	2014	22.9
54	Камержуулалтын ажил	УБ, СХД	НЗДБУБ ХЗ НОНХС	1,600.0	1,585.4	2014	2015	1,426.8
55	361 дүгээр гарам орчим цагдаагийн хэсгийн байр барих	УБ, СХД, 21 дүгээр хороо	НЗДБУБ ХЗ НОНХС	151.9	137.1	2017	2017	137.1
56	Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил	УБ, БЗД, 8, 12 дугаар хороо	НЗДБУБ ХЗ НОНХС	40.0	39.9	2018	2018	38.9



57	Автомашин зогсоол байгуулах /СХД, 14 дүгээр хороо, 12, 13 дугаар байр орчимд/ түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй	УБ, СХД, 14 дүгээр хороо	НЗДБУБ ХЗ НОНХС	20.0	20.0	2018	2018	10.0
58	"Эко Дамбадаржаа" хорооллын гадна ус, дулаан хангамж, ариутгах татуурга, зуухны барилга, УДДТ, зуухны тоног төхөөрөмжийн угсралтын ажил, зураг төсөв боловсруулах	УБ8 СБД, 15 дугаар хороо	НЗДБУБ ХЗ НТХО	5,598.1	5,598.1	2013	2015	2,455.9
59	Баянзүрх дүүргийн 3 дугаар хороо 11Б байр, Баянзүрх дүүргийн 7 дугаар хороо 2 дугаар байрны 3 дугаар орцны дээврийг Касари дээврээр солих ажил	УБ, БЗД, 3, 7 дугаар хороо	НЗДБУБ ХЗ НТХО	20.0	20.0	2017	2017	8.0
60	Дүүргийн спорт цогцолбор, 1000 суудал	УБ, СБД	ОНБТСУ ХД	9,936.9	9,936.9	2010	2023	3,833.8
61	Нийслэлийн спорт цогцолбор, 1000 суудал	УБ, ХУД	ОНБТСУ ХД	7,280.2	7,280.2	2010	2023	-
<b>НИЙТ ДҮН</b>				<b>201,406.0</b>	<b>194,016.6</b>			<b>88,843.9</b>



**Хавсралт 5**

Хүснэгт 18 Барилгын материалын үнийн өсөлт тооцсон зарим төсөл арга хэмжээний хүрээнд галд тэсвэртэй хөөсөнцөр хавтан /150мм/-д үнийн өсөлт тооцсон байдал

№	Төсөл, арга хэмжээний нэр	Эхлэх, дуусан огноо	Төсөвт өртөг	Гэрээний дүн	2015-2020 онд авсан ажлын гүйцэтгэл	Үлдэгдэл тооцох дүн, /2021 оноос хойш/	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	БХБЯ-ны баталсан жишиг үнээр тооцсон дүн	Үнийн өсөлт тооцуулсан үнэ	Зөрүү үнэ	Материалын үнийн өсөлтийн зөрүү, НӨАТ-гүй	Материалын үнийн өсөлтийн зөрүүний НӨАТ	Материалын үнийн өсөлтийн зөрүү, НӨАТ тооцсон дүн
1	2	3	4	5	6	7 = (5-6)	8	9	10	11	12=(11-10)	13=(12 *9)	14=(12*1.1)	15=(13+14)
1	Нийтийн зориулалттай орон сууцны барилгын фасад /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 1 дүгээр хороо, 57, 61, 68 дугаар байр, 3 дугаар хороо 50 дугаар байр/ Багц-1	2021-2022	1,120.10	1,115.08	-	1,115.08	м2	9,261.0	0.05	0.05	0.00	27.84	2.78	30.62
2	Нийтийн зориулалттай орон сууцны барилгын фасад /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 4 дүгээр хороо 2а байр, 6 дугаар хороо 13, 15 дугаар байр, 7 дугаар хороо 33 дугаар байр/	2021-2022	1,317.60	1,285.03	-	1,285.03	м2	11,205.4	0.05	0.05	0.00	28.27	2.83	31.09
3	Нийтийн зориулалттай орон сууцны барилгын фасад /Улаанбаатар, Баянгол дүүрэг 8 дугаар хороо 9б, 11 байр, 9 дүгээр хороо сот 2-2, сот 3-2 байр	2021-2022	1,225.20	1,188.44	-	1,188.44	м2	12,922.6	0.05	0.05	0.00	38.85	3.88	42.73
4	Нийтийн зориулалттай орон сууцны барилгын фасад /Улаанбаатар, Баянгол дүүрэг 5 дугаар хороо 12б байр, 13 дугаар хороо 2б, 2в байр, 14 дүгээр хороо 16 дугаар байр / Багц-6	2021-2022	1,206.80	1,107.32	210.29	897.03	м3	1,673.0	0.30	0.32	0.02	28.14	2.81	30.95



5	Нийтийн эзэмшлийн орон сууцны байруудын дулаалга /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 19 дүгээр хороо, 59 дүгээр байр, 15 дугаар хороо, 32 дугаар байр, 18 дугаар хороо, 43 дугаар байр/	2021-2021	1,040.00	1,038.51	-	1,038.51	м2	7,677.0	0.05	0.05	0.00	19.37	1.94	21.31
6	Нийтийн эзэмшлийн байруудын дулаалга /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 4, 8, 17 дугаар хороо/	2021-2021	1,000.00	838.74	-	838.74	м3	7,735.4	0.05	0.05	0.00	19.52	1.95	21.47
Зөрүүгийн дүн			6,909.70	6,573.12	-	-			-	-	-	-	-	178.17

Хүснэгт 19 Эрчим хүчний хөгжлийн төвөөс зарим нэр төрлийн барааны үнийн өсөлтийг тооцсон байдал /мянган төгрөг/

№	Төсөл, арга хэмжээний нэр	Эхлэх, дуусан огноо	Төсөвт өртөг	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	БХБЯ-ны баталсан жишиг үнэ 1	БХБЯ-ны баталсан жишиг үнэ 2	Үнийн өсөлт тооцуулсан үнэ	Зөрүү үнэ	Материалын үнийн өсөлтийн зөрүү, НӨАТ-гүй	Материалын үнийн өсөлтийн зөрүүний НӨАТ	Материалын үнийн өсөлтийн зөрүү, НӨАТ тооцсон дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
1	Дулааны станцын 2 дугаар хэлхээний шугам засвар, шинэчлэл-3 дугаар ээлж /Хэнтий, Хэрлэн сум/	2021-2023	5,900.0	Бөмбөлгөн хаалт ф125-мм	Ш	10	392.7	958.8	958.8	566.1	5,660.7	566.1	6,226.7
				Бөмбөлгөн хаалт ф-80-мм	Ш	29	164.8	286.0	286.0	121.2	3,515.6	351.6	3,867.1
				Бөмбөлгөн хаалт ф-200-мм	Ш	12	1,309.1	2,702.1	2,702.1	1,393.0	16,716.4	1,671.6	18,388.0
				Бөмбөлгөн хаалт ф-150-мм	Ш	8	469.1	1,375.0	1,375.0	905.9	7,247.3	724.7	7,972.0
2	Сайхан, Хутаг-Өндөрийн сумын заагт орших "Дондогийн булаг" орчмыг цахилгаан эрчим хүчний системд холбох /Булган, Сайхан сум/	2021-2021	395.0	Төмөрбетон тулгуур УКШ 9.27.15 /0.55 тн/	Ш	28	345.55	581.82	581.8	236.3	6,615.6	661.6	7,277.2
				Төмөрбетон тулгуур УКШ 12.35.19 /0.55 тн/	Ш	4	581.82	660.00	660.0	78.2	312.7	31.3	344.0
Зөрүүгийн дүн													44,075.12



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 10 дугаар сарын 06 № 984/АОИ10001  
АНГ-2022/14-УТА-ТК

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Монгол Улсын 2023 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг 2010 онд баталж мөрдүүлснээс хойш 11 удаа төсвийн хүрээний мэдэгдлийг баталсан боловч 2015 оны Төсвийн тухай хуулиас бусад тохиолдолд жилийн төсвийн төслийг төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэх бус төсвийн хүрээний мэдэгдлийг тухайн жилийн төсөвтөө тааруулан өөрчилдөг байсан тул өмнөх аудитаар Монгол Улсын Засгийн газарт зөвлөмж хүргүүлсэн. Гэвч Монгол Улсын Засгийн газар Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн төслийг боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхдээ энэ зөвлөмжийг хэрэгжүүлэлгүй 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд дахин өөрчлөлт оруулах санал гаргажээ.

Төсвийн хүрээний мэдэгдлийн ач холбогдол үнэ цэнэ буурснаар төсвийн удирдлагын зарчим алдагдаж, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг үндэслэлгүй боловсруулах, төсвийн бодлого тогтворгүй, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн зорилт хангагдахгүй байх нөхцөлд хүргэж болзошгүй байна.

Төсвийн сахилга, хариуцлагыг шат шатандаа олон жил хэрэгжүүлж ажиллаагүйгээс төсөв, санхүүгийн зохистой харьцаа алдагдаж, залруулах боломж цаашид хязгаарлагдаж, сөрөг үр дагавар нэмэгдэх эрсдэлтэй тул Монгол Улсын Их Хурлын "Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" 2021 оны 88 дугаар тогтоолын 1.6-д "Монгол Улсын тухайн жилийн төсвийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхдээ дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэх ...", 1.8-д "Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн төсөлд дүгнэлт өгсөн аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах ..." -ыг Монгол Улсын Засгийн газарт даалгасан ч хэрэгжилт бүрэн биш байна.


Төрийн аудитын байгууллага өмнөх аудитаар өгсөн төсвийн хүрээний мэдэгдлийг өөрчлөхгүй байх буюу хүчин төгөлдөр үйлчилж буй төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн жилийн төсвийн төслийг боловсруулах, төсвийн захирагч нарын хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг зохих шаардлагад нийцүүлэх зэрэг зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах тухай 2022 оны 9 дүгээр сарын 5-ны өдрийн 1539 дүгээр албан бичгийг Монгол Улсын Засгийн газарт хүргүүлсэн.

Монгол Улсын Засгийн газар Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-т “Төсвийн төсөл боловсруулах, батлах, батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулахдаа дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлнэ.”, 7.4-д “Энэ хуульд зааснаас бусад тохиолдолд төсвийн тусгай шаардлагыг баримтлахгүйгээр дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл боловсруулах, батлах болон дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэхгүйгээр төсвийн төсөл боловсруулах, батлах, батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно.”, Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.4-д “жилийн төсвийн хязгаарт үндэслэсэн байх” гэж заасныг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.10-т “аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Монгол Улсын жилийн төсвийн төслийг төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн боловсруулах горим тогтолцоог боловсронгуй болгох арга хэмжээ авч, биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид энэхүү албан шаардлагад дурдсан алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга (Д.Амарбаясгалан), Монгол Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд (Б.Жавхлан) нарт даалгав.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ЗАНДАНБАТ







Үндэсний аудитын газар  
/Засгийн газрын IV байр/



[www.audit.mn](http://www.audit.mn)



[info@audit.gov.mn](mailto:info@audit.gov.mn)



(+976) 62-263230



(+976) 62-263230

